

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 14-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-7

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 8-44

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал 8-11

2.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх// 11-26

3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ./ 26-44

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 04 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баярбаатар, Э.Болормаа, С.Бямбацогт, Т.Доржханд,
Л.Мөнхбаатар, Н.Учрал, Л.Гантөмөр, Ц.Туваан;
Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 12
Бүгд: 14
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 3.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүнээс 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 4.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Амгалан, мөн Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, ажлын хэсгийн дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут нар танилцуулав.

Илтгэл болон ажлын хэсгийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар, Ө.Шижир, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар, Н.Номтойбаяр, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

З.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хэлэл Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов, Орон нутаг хариуцсан хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ахдах референт Ч.Ариунаа, Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн референт Ц.Ренчиндулам, референт Ж.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов нар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Г.Уянгахишиг, Б.Уянга, Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов, Орон нутаг хариуцсан хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ахлах референт Ч.Ариунаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 11 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 14-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
13 цаг 04 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн та бүхэнд танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн. Дашзэвэгийн Амарбаясгалан гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн ирсэн. Жудгийн Баярмаа гишүүн ирсэн байна. Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2025 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль/шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд Засгийн газар 2025 оны 5 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх,

Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд сонгох, сонгогдох эрх болон сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал. Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн илтгэлийг сонсоно, хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоомжийн төслүүдийг чуулганаар хэлэлцэх эсэхийг шийдүүлэх тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэх, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. Ингээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Эхний санал хураалт Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль/шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралд хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаа хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Миний аппарат ажилласангүй. Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Дарга төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг дахин явуулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Дарга уучлаарай тэнд төхөөрөмж ерөөсөө танихгүй байна тэгээд би төхөөрөмжөө сольж байна. Дахин санал хураалт явуулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Дахин санал хураалт явуулъя гэсэн Зулпхар гишүүний саналын дагуу санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Минийх бас болсонгүй санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын санал хураалт явуулъя. Саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

14-өөс 8 гишүүн санал өгч, 57.1 хувиар санал дэмжигдлээ.

Одоо санал хураалт санал хураалт. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолыг Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлгийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 14 гишүүнээс 9 гишүүн оролцож, 64.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Уг нь зөвшөөрсөн тэр дарсан машин ажилласангүй юу яав.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

14 гишүүнээс 9 гишүүн санал өгч, 64.3 хувиар санал дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулъя.

Санал хураалт миний аппарат бас ажилласангүй. Хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна. Санал хураалт.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.Ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж, нууц санал хураалтыг цахимаар эсхүл санал хураах хуудсаар явуулна гэж заасны дагуу гар өрж өргөж санал явуулъя гэсэн санал оруулж байна. Горимын санал оруулж байна. Машин болохгүй. Тэгвэл гараар санал хураалт явуулъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ чинь 14-өөс 9 гишүүн дэмжиж, гар өргөж 8 уу? 8 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хүчингүй болсон тул саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

14 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

14 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүнээс 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлгийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

14-өөс 9 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасанд заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

14 гишүүнээс 9 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ. Болсон уу?

Дараагийн асуудал оръё.

13.08 цаг

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Ажлын хэсгийг оруулъя. Хууль санаачлагч санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн танилцуулна. Эрдэнэбүрэн гишүүний микрофоныг нээе.

Р.Эрдэнэбүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хуулийг батлан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндэс эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 12 сарын 20-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг батлан хэрэгжүүлж ирсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж өөрчлөн найруулсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд “Хууль, тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын хавсралтад заасны дагуу улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтоож, хот, тосгоны өөрийн удирдлагыг оршин суугчид нь сонгож, хот, тосгоны удирдлага, засаг захиргаа, нутаг дэвсгэр дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон төсөв санхүүгийн зарим эрх мэдлийг шилжүүлэх, эдийн засгийн хувьд хот, тосгон харьцангуй бие даа хөгжих боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг тусган Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн батлуулахыг Засгийн газарт үүрэг болгосон.

Монгол Улсын үндсэн хуулийн энэ үзэл баримтлалын хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурал 2024 оны 6 сарын 5-ны өдөр өдрийн дотор баталсан. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 8 бүлэг 54 зүйлтэй бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, нийтлэг журам, хотын зэрэглэл тогтоох шалгуур, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчтай харилцах харилцааг зохицуулж, 2025 оны 6 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр баталсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 24 оны 6 сарын 5-ны өдөр хот байгуулах тухай 72 дугаар тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолоор Дархан, Эрдэнэт, Зуунмод, Хархорум, Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 6 хот, орон нутгийн зэрэглэлтэй 43 хот, үүнээс 14 нь нийслэлд дагуул 4, үүнээс 3 нь нийслэлд байхаар хотуудыг байгуулсан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон Хот байгуулах тухай Улсын Их Хурлын 24 оны 6 сарын 5-ны өдрийн 72 дугаар тогтоолд заасны дагуу дээр дурдсан 52 хотын Хархорумоос бусад эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч хөрөнгө, төсөв, байгууллагын бүтэц, орон тоог шилжүүлэх зэрэг ажлыг орон нутагтай зөвшилцөх болон зохион байгуулахад багагүй хугацаа хэрэгтэй байгаа тул Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх хугацааг хойшлуулах шаардлагатай байна гэж үзэж байгаа.

Тухайлбал, Нийслэл Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг 189 хороонд нийт 3341 төрийн албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 14 хот 42 хорооллоор дамжуулан төрийн үйлчилгээг үзүүлэхэд урьдчилсан байдлаар 2380 төрийн албан хаагч ажиллах тооцоолол гараад байгаа. Өөрөөр хэлбэл, ажлын байрны давхардал, орон тооны цомхотгол, шинэ бүтэц, зохион байгуулалт гэх мэт олон асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд орсон зарчмын өөрчлөлт бол хот, тосгоны өөрийн удирдлагын байгууллага нь хот, тосгоны зөвлөл байх зохицуулалт юм.

Хот нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 69.1, 69.2-т заасны дагуу шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд энэ хүрээнд 31 нийтлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульд заасан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймаг, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч тэдгээрээс нэр дэвшүүлж томилогдсон Засаг дарга нь 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хотын зөвлөлд захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл харьяалах хотын зөвлөл

захирагчийн хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан хэдий ч уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тодорхой бэлтгэл хангах шаардлагатай гэж үзлээ.

Иймд Улсын Их Хурлаас 2024 оны 6 сарын 5-ны өдөр баталж, 25 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон үүнтэй холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулах тухай Улсын Их Хурлын 24 оны 72 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг тус тус боловсрууллаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийг танилцуулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль төслүүдийн ажлын хэсгийг танилцуулъя. П.Зоригтбаатар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга, Д.Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Т.Даваадалай НЗД-ын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Д.Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, Ч.Төгсдэлгэр Нийслэлийн ерөнхий аудитор, М.Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Г.Мөнхбаатар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг байгаа. Энэ ажлын хэсгийн ахлагч Батлут гишүүн дүгнэлт байгаа өөрт нь тээ? Дүгнэлтээ танилцуулъя. Батлут гишүүний микрофоныг өгье.

Д.Батлут: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 77 дугаар захирамжаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай бол хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагчаар Батлут миний бие, ажлын хэсгийн гишүүнээр Жуковын Алдаржавхлан, Наранцэцэгийн Алтаншагай, Жигжидийн Батжаргал, Халтмаагийн Баттулга, Пүрэвжавын Ганзориг, Гонгорын Дамдинням, Цагаанхүүгийн Идэрбат, Ганзоригийн Лувсанжамц, Сүрэнжавын Лүндэг, Нанзадын Наранбаатар, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг нарын гишүүдийн гишүүд нарийн гишүүд ажилласан болно.

Ажлын хэсгийн ажлын хэсгийн хуралдаанаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явцын талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 20 минутын хот Үндэсний хорооноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл сонсож, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж харилцан санал солилцсон болно.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж ажлын хэсгээс үзлээ. Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэх талаар судалгаа хийж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газраас Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх.

2.Монгол Улсын Засгийн газраас улсын зэрэглэлтэй болон орон нутгийн зэрэглэлтэй хотуудын эдэлбэр газрын хил, заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээ, дагуул хотуудын эдэлбэр газрын хил заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг тогтоох талаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж өргөн мэдүүлэх.

3.Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан 54 хотын эдэлбэр газрын зураглалыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэх, ялангуяа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй шинээр зурагласан 8 хотын асуудал, улсын зэрэглэлтэй хот болоход аймаг, сум дамнасан тохиолдолд газар зүйн байршил, хотын эдэлбэр газрын хэмжээ зааг зэрэгт шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах.

4.Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд шаардлагатай дүрэм, журам, аргачлал, эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах.

5.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хууль тогтоомжийн талаар Засгийн газар, 20 минутын хот Үндэсний хороо ойлголтоо нэгтгэх, удирдлага, зохион байгуулалтын ажлын уялдааг сайжруулахад анхаарах.

6.Засгийн газраас иргэд, олон нийтэд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн талаар нэгдсэн ойлголт өгөх, мэдээллээр хангах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Иймд ажлын хэсгээс Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхэд Засгийн газрын бэлтгэл ажил хангалттай хийгдээгүй, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйг дүгнэсэн тул уг хуулийн хэрэгжих хугацааг 1 жилээр буюу 2026 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хойшлуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санал санаачлагчийн илтгэл, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Батбаатар гишүүнээр тасаллаа. Шижир гишүүн, Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би хувьдаа энэ хуулийн төслийг дэмжихгүй байгаа. Засгийн газар яагаад хуулиа хэрэгжүүлэхгүй байна вэ? Хуулийн төслийн үзэл баримтлалыг харахаар бэлтгэл ажил хангагдаагүй гэдэг шалтгаанаар, шалтгаар хуулийн төслийг 1 жилийн хугацаатай хойшлуулъя гэж оруулж ирж байгаа юм байна. Ямар бэлтгэл ажил хийх гэсэн чинь хангагдахгүй байгаа юм? Өнгөрсөн хууль батлагдсанаас хойш 1 жилийн хугацаанд Засгийн газар энэ хуулийг хэрэгжүүлэх хүрээнд ямар ажил хийсэн юм, ямар бэлтгэл ажлыг хангасан

юм? Би хувьдаа огт бэлтгэл ажил хийгээгүй гэж бодож байгаа. Энэ талаар ямар ч гар хөдөлгөөгүй, ажил хийгээгүй. Энэний нэг илрэл нь сая өнгөрсөн 4 сард чуулган дээр би бас Сангийн сайд, Сангийн яамны холбогдох мэргэжилтнүүдээс асуухад энэ талаар ямар ч ойлголт байхгүй байсан. Энэний цаана дандаа төсөв хөрөнгийн асуудал байгаа. Төсөв санхүүгийн өөрчлөлт, орон нутагт төсвийн эрх мэдлийг олгох, татвар, төсөв санхүү, татварын асуудал гээд ингээд олон асуудлууд хийгдэх ёстой. Гэтэл Сангийн яам нь энэ тал дээр ямар ч ойлголтгүй байсан.

Тэгээд Засгийн газар ямар бэлтгэлийг хийх гээд 1 жилээр хойшлуулж байгаа юм, юу хийсэн юм өнгөрсөн хугацаанд? 26 оны 1 сарын 1-нээс амжих юм уу 1 жилээр хойшлуулахад? Өөр шалтгаан байгаа юм уу? Энэ хууль ер нь Үндсэн хуультай зөрчилдөж байгаа асуудал байгаа юу? Өөр бусад хуультай зөрчилдөж байгаа асуудал байгаа юу? Энэ нь хойшлуулах шалтаг, шалтгаан мөн үү, үгүй юү, байсан уу, үгүй юү? Эсвэл бэлтгэл ажлыг хэн хийх ёстой юм? Засгийн газар хангах ёстой шүү дээ бэлтгэл ажлыг. Бэлтгэл ажил хангагдаагүй учраас энэ хуулийг өөрчилж, хойшлуулж байна гэдэг өөрөө бас шалтаг, шалтгаан биш шүү биш.

Үнэхээр хууль хоорондын зөрчил, Үндсэн хууль дээр зөрчилдөх асуудал байсан юм гэж үзэж байгаа бас бол өөр хэрэг. Тэгээд энэ чинь бүтэн жилийн өмнө хууль батлагдсан өнөөдрийг хүртэл юу ч хийгээгүй, энэ хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр ямар ч арга хэмжээ аваагүй, ямар ч уулзалт, ямар ч орон нутагт ажилласан юм байхгүй. Иргэддээ уулзалт танилцуулсан юм байхгүй. Би хараад л яваад байсан. Энэ хуулийг чинь батлуулах гэж бас тухайн үеийн хотын удирдлагуудтай ажлын хэсгийнхэнтэй нэлээн ажиллаж ач холбогдол өгч байж батлуулсан шүү дээ. Харамсалтай нь хууль батлуулаад л тэгээд л сонгуульдаа бүгд мордоцгоосон. Сонгуулийн үр дүнгээр өнөөдрийг хүртэл ингээд л бүгд бялуураад л юу ч хийхгүй явж байгаа шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд. Хууль хэрэгжүүлэх.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбүрэн сайд хариулах уу?

Р.Эрдэнэбүрэн: Хуулийн дээрээс нь нэмж хариулах хүмүүс байвал манай ажлын хэсгийнхэн нэмээд бас хариулаарай. Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Алдаржавхлан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг 20 минутын хот Үндэсний хороон дээр байгуулагдаад ажилласан. Хамгийн хүндрэлтэй зүйл бол энэ эдэлбэр газрын хил хязгаарыг тогтоох асуудлууд байгаа. Зарим ерөнхийдөө бид нар зарчмын хувьд ерөнхий төлөвлөгөөнийхөө хилээр эдэлбэр газраа тогтоогоод явъя гэдэг ийм зарчим дээр ажилласан. Нэлээн олон газар бол хил хязгаараа бол ойлголт, санал нэгдсэн газрууд бол нэлээн олон байгаа. 7, 8 шинээр байгуулагдах нь хотын ерөнхий төлөвлөгөөгүй зарим газрууд байгаа. Тийм учраас эдгээр ерөнхий төлөвлөгөөгүй байгаа газрууд дээр ерөнхий төлөвлөгөө их батлуулж өгөх энэ ажлууд хийгдэж байна. Энэ ажил бас нэлээн их цаг авч байгаа.

Хоёр дахь үндсэн шалтгаан бол энэ хууль өмнөх Их Хурлын үед батлагдсан хууль байгаа. Миний хувьд бол Үндсэн хуультай зөрчил бол байхгүй, Үндсэн хууль зөрчсөн зүйл байхгүй байна гэж ингэж үзэж байгаа. Маш олон гишүүд бол энэ дээр Үндсэн хууль зөрчсөн гэдэг ийм санал ярьж байгаа. Тэгэхлээр энэ хуулиа яг хэрэгжүүлж явахад бол бүгдээрээ нэгдсэн ойлголттой болж авах шаардлагатай байгаа Улсын Их Хурлаасаа эхлээд. Тэгж байж байж хэрэгжүүлж эхлэхгүй бол шууд ингээд явахлаар бас янз бүрийн хэл ам гараад ингээд хуулиа хэрэгжүүлж чадахгүй бүүр унагачих вий гэж ингэж санаа зовж байгаа. Тийм учраас энэ

сунгасан хугацаандаа ойлголтоо нэгтгэх чиглэлээр их ажил хийх шаардлагатай байгаа гэж ингэж үзэж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн нэмэлт асуулт.

Ц.Сандаг-Очир: Асуухад ч хэцүү л юм даа. Тайлбар ч гэж. Яг тэгээд 1 жилийн дараа 26 оны 6 сарын 1 удахгүй л хаяанд ирнэ. Та нарын бэлтгэл хангаж чадахгүй байгаа ажил тэгээд 1 жилийн хугацаанд хангагдах юм уу, жилийн хугацаанд хангаж чадах юм уу Эрдэнэбүрэн сайд аа? Ахиад 26 оны 6 сарын 1-нд гээд ахиад хуулийн хугацаа хойшлох бэлтгэл ажил хангагдсангүй гээд хойшлуулах гээд сууж байх вий дээ. 1 жилийн хугацаанд тэгээд бэлтгэлийг нь хангаж амжих юм уу? Хангана гээд бүрэн дүүрэн хариулж, хариулт өгч чадах уу? Тэгж байгаа бол хамаа алга. Энэ хуулийг чинь дэмжье.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбүрэн сайд хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Энэ эдэлбэр газар тогтоох, бусад эрх шилжүүлэх ажлууд эд нар бол асуудалгүй шийдэгдэнэ. Хамгийн гол ажил бол Их Хурал дээрээ Их Хурлын гишүүд маань бүгдээрээ нэг ойлголттой л болж байх хэрэгтэй. Үндсэн хууль зөрчсөн юм уу, зөрчөөгүй юу гэдэг дээрээ. Тэгээд энэ бол энэ хууль хэрэгжүүлэх хамгийн чухал ажлын нэг гэж ингэж бодож байгаа. Тэгээд одоо энэ чиглэлээр бас бэлтгэл ажлууд хийгдэнэ. Олон уулзалт, хурал зохион байгуулах шаардлагатай байгаа.

Тийм учраас ямар ч байсан энэ сунгасан хугацаандаа бол бүх бэлтгэл ажлуудыг хийж чадна гэж ингэж үзэж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Засгийн газар ажлаа хийж чадаж байгаа юм уу гэж асуугаад байна шүү дээ. Түүнээс биш Их Их Хурлын гишүүд ойлголт нь байна уу, үгүй байна уу гэсэн асуулт асуугаагүй шүү дээ Засгийн газар яг юу хийсэн юм бэ гэж л хэлээд байна шүү дээ. Эрдэнэбүрэн сайд.

Р.Эрдэнэбүрэн: Засгийн газраас энэ гол хамгийн түрүүнд хийгдэх ажил бол эдэлбэр газрын хэмжээг тогтоох байгаа. Тэгээд энэ чиглэлээр ажлуудаа хийж байгаа. Хэд хэдэн газар ерөнхий төлөвлөгөөгүй газар байна, газрууд байна. Ерөнхий төлөвлөгөөнүүдийг яаралтай хийлгүүлэхээр ингээд явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Батлут гишүүн ажлын хэсгийн дарга.

Д.Батлут: Өдрийн мэнд хүргэе. Гишүүд маань тал талын өөр өөр өнцгийн ойлголттой байна яг үнэндээ. Одоо 20 минутын хот гээд энэ төслийн сайдын хувьд Үндсэн хууль дээр зөрчилдөх зүйл ер харьцангуй байхгүй гэдгээ хэлж байна. Магадгүй нийслэл хот дээр тийм байх магадлалтай. Гэхдээ орон нутаг дахь тухайлбал, Дархан-Уул аймаг, Эрдэнэт хот, Орхон аймагтай холбоотой асуудал дээр шал өөрөөр харагдаж байгаа юм. Тэгээд хууль, эрх зүйн хувьд ойлгомжгүй байдал үүсээд байхаар яг үнэндээ Засгийн газар тэн дээр хийх ажил нь тодорхой биш болчихоод байгаа юм л даа. Тэн дээр хийж чадах, хийх зүйл үнэхээр хэцүү болчихоод байгаа юм. Одоо энэ хууль гарсантай холбоотой Дагаж мөрдөх журмын тухай хууль гэж байгаа. Дагаж мөрдөх журмын тухай хуулиар тухайлах юм бол Эрдэнэт хотын зөвлөлийн асуудлыг Орхон аймгийн ИТХ, Эрдэнэт хотын

Захирагчийн ажлыг Орхон аймгийн Засаг дарга бүр хотын статустай болтол ингээд хариуцаад явах юм гэж. Тэгвэл түүнд байгаа d.parliament.mn

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Энэ улс төрийн намын бүртгэлийн хугацааг хойшлуулах асуудал яг энэ шиг орж ирсэн. Тэнд иргэдийн эвлэлдэн нэгдэх тухай асуудал байсан. Тэгээд тэр хууль дээр гишүүд янз бүрийн л байр суурь барьсан. Батлутаа чимээгүй байж байгаач хөөе. Батлутаа өөрийнхөө микрофон дээр ярь л даа. Хүний цаг эхэлчхээд байхад чинь дундуур нь ороод байх юм. Энэ цагийг нь дахиад өгчих дөө. Хүрэхгүй бол нэмээд тавьчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн дахиад минутыг нь өгье.

Б.Батбаатар: Улс төрийн намын тухай хуулийн бүртгэлийн асуудал дээр хугацаа хойшлуулахад гишүүд янз бүрийн байр суурьтай байсан. Намууд чинь өөрсдөө хурлаа хийчхэж чаддаггүй юм уу гээд. Тэр нь сүүлдээ улс төрийн хувьд Засгийн газар нь тогтох, тогтохгүй тухай ярьж байсан. Тэнд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал хөндөгдөж байсан учраас хойшлуулахыг нь дэмжиж байсан. Одоо харин энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулах асуудлыг оруулж ирж байгааг үндсэндээ дэмжихгүй байна. Нэгд нь энэ ажлын хэсэгт Засгийн газар орсон. Улаанбаатар хотын төлөөлөл орсон. Эндээсээ хойшлуулах саналыг оруулж ирж Их Хурал дээр танилцуулж байна гэдэг Засгийн газар, Нийслэл хот 2 ажлаа хийж чадахгүй байгаагаа илэрхийлж байгаа хэлбэр л гэж ойлгож байгаа.

Ажлаа хийж чадахгүй болохоор хуулийг хэрэгжүүлж чадахгүй ,хуулийг хэрэгжүүлж чадахгүй учраас хугацааг нь хойш нь сунгая. Ийм төрийн албатай байх нь хэцүү. Хууль батлагдаж байх үеийн Засгийн газар өнөөдөр тэр чигээрээ үндсэндээ үргэлжилж байгаа шүү дээ. Ерөнхий сайд нь солигдоогүй. Их Хурал дээр байдаг кнопынхоо тоог 118 болгож нэмсэн. Улаанбаатар хотын удирдлага улс төрийн намаасаа солигдоогүй, өөрчлөлт ороогүй. Хууль батлагдаж байх үед л эрх барьж байсан нөхдүүд өнөөдөр үргэлжлүүлэн эрхээ бариад хүчээ нэмээд явж байгаа.

Тэгээд энэ хуулиа хэрэгжүүлж чадахгүй юм бол хууль хэрэгжүүлж чадсан, чадаагүй дээрээ тулаад, хуулийнхаа өөрчлөлтийг хийх ёстой хийгээд хуулийн хэрэгжилтийг Их Хурлын өмнө Засгийн газар хариуцна гэдэг хуультай шүү дээ. Тэр хуулиа зүгээр хаячхаж байна шүү дээ. Энэ хуулийг хэрэгжүүлж чадахгүй байгаа учраас хугацааг нь хойшлуулъя гээд Их Хурал руу тогтоолын төслүүд болон бусад зүйлүүд орж ирж байгаа. Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолуудын хэрэгжилт гэхэд өнөөдөр хэдэн хувьтай явж байгаа юм? 20 жилийн өмнөх тогтоол хэрэгжээгүй байна гээд, 10 жилийн өмнөх, 1 жилийн өмнөх. Энэ тогтоолууд, хуулиуд хэрэгжүүлэх үүрэгтэй Засгийн газар нь хэрэгжүүлж чадахгүй байна шүү дээ. Тэгэхээр ажлын хэсгээс асуух гээд байгаа юм нь Улаанбаатар хот энэ ажлаа хийж чадахгүй байгаа юм уу, Засгийн газар улс орны хэмжээнд орон нутгаа удирдан зохион байгуулах хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж чадахгүй болчихоод орж ирж байгаа юм уу? Сонгуулиар засаг төр нь солигдоод бодлогоо өөрчиллөө гэсэн бол бас арай өөр өнцөг харагдах байсан. Энэ дээрээ хариулт хэлээч. Их хурлын гишүүд ойлгохгүй байгаа учраас. Их Хурлаар батлагдсан хуулиа ойлгодоггүй. Их Хурлын.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбүрэн сайд хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Үгүй яах вэ Их Хурлын гишүүдийн ойлголтгүй байгаа ч гэж хэлээгүй л дээ. Ойлголцол зөрүүтэй байгаа санал юунууд. Их Хурлын гишүүд бол сая Батлут гишүүн ч хэллээ ажлын хэсэг дээр бид бас ярьж үзсэн зөндөө. Зарим гишүүд бол энэ Үндсэн хууль зөрчсөн гээд байгаа. Тэгэхлээр энэ ойлголтынхоо зөрүүг арилгах хэрэгтэй байгаа. Үнэхээр Үндсэн хууль зөрчсөн юм уу, зөрчөөгүй юм уу гэдэг дээрээ нэг тал руугаа гарах хэрэгтэй байгаа.

Хоёрт нь бол мэдээж олон механик ажлууд хийгдэх ёстой. Эдэлбэр газрын хил хэмжээ тогтоох энэ тэр гээд. Тэгээд энэ дээр бол бас цаг шаардлагатай байгаа гэж хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн дахиад тодруулъя.

Б.Батбаатар: Ажил ажлын хэсэгт байхгүй сайд нь хариулт өгч байгаа тэр бас өөрөө гүйцэд юмаа ойлгохгүй байгаа юм болов уу л гэдэг өнцөг харагдаад эхэлж байна. Засгийн газар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Үндсэн хууль зөрчиж байгаа учраас бид бид хэрэгжүүлж чадахгүй гэж байгаа бол тэрийгээ Цэцэд өг л дөө. Улсын Их Хурал бидэнд хууль хэрэгжүүлэх үүрэгтэй, хууль баталж өгөхдөө Үндсэн хуулийг зөрчсөн ийм хууль батлаад өгчихжээ. Их Хурлын гишүүд Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй тухай янз бүрийн ойлголттой байна гэдэг утгаар лоббины аргаар танин мэдэхүйн хичээл заах арга замаар энийг өөрчилнө гэж байхгүй шүү дээ. Түрүүн бас асуусан Засгийн газар ажлаа хийж чадаагүй юм уу, Улаанбаатар хот ажлаа хийж чадаагүй болоод энэ хууль хойшлуулж байгаа юм уу гэж хариулахгүй байна шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Асуулт уу? Хэн хариулах юм? Бие бие рүүгээ чихээд байна уу, үгүй юу? 4 номер.

П.Зоригтбаатар: Зоригтбаатар Орон нутгийн удирдлагын дарга. Бид хууль батлагдсанаасаа хойш мөн Дагаж мөрдөх журмын тухай хууль гарснаас хойш Дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар холбогдох орон нутгийн газар, удирдлагуудтай, нутгийн ... болон Засаг дарга нартай яаж энийг, энэ бүтцийг хийх вэ гэдэг талаар удаа дараа хэлэлцүүлэг хийгээд уулзалт хийгээд явж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрт, энэ 72 дугаар тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсний дагуу Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Нийслэлийн газрын харилцааны алба улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотууд дагуул хотуудын эдэлбэр газрын хэмжээг ерөнхийдөө одоогийн суурьшлын бүсээр тогтоогоод, шаардлагатай хэмжээгээр тогтоогоод явж байгаа. Тэгээд энэ дээр эргээд ярихлаар зэрэг хот, тосгоны захирагч газар олгох эрх мэдэлтэй байх уу гэдэг асуудал бас яригдсан. Тэгэхээр өөр аймгийн, өөр нэгжийн нутаг руу дамнан байрлаж байгаа хотын эдэлбэр газар дээр газар олгох асуудал нь нөгөө аймгийн хилийн цэс өөрчлөгдөөгүй нөхцөлд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерыг дахин судалъя.

П.Зоригтбаатар: Энэ асуудлууд асуудлуудыг бас нэг мөр болгоход нэлээн хугацаа, хуульд нь өөрчлөлт оруулах хугацаа авах шаардлага гарч байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт бид Захирагчийн ажлын албанууд ямар бүтэцтэй байх вэ гэдэг ийм тооцоо гаргаад нийслэлээс бусдаар нэгжүүд дээр бид нар тооцоо гаргаад явсан. Энэ тооцоогоор бол улсын зэрэглэлтэй хот болон орон нутгийн зэрэглэлтэй хот дагуул хотуудад нийтдээ одоо байгаа нэгж дээр нэмэгдээд хот, тосгоны нийтдээ 693 орон тоо ойролцоогоор тооцсоноор бол 700-гаад орон тоо нэмэгдэхээр гарч байгаа.

Яаж давхцаж гарч байгаа вэ гэхлээр би Дархан хотын жишээгээр энэ жишээ авъя л даа. Дархан-Уул аймаг өөрөө нэгжийнхээ хуулийн дагуу оршин тогтноно. Дархан сум өөрөө нэгжийн хуулийн дагуу оршин тогтноно. Дархан сум дотор улсын зэрэглэлтэй Дархан хот байгуулагдана. Дархан хот нь, Дархан-Уул аймаг нь Иргэдийн хуралтай, Засаг даргатай, Тамгын газартай. Дархан сум өөрөө иргэдийн хуралтай, Засаг даргын Тамгын газартай улсын зэрэглэлтэй Дархан хот хотын зөвлөлтэй 21.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон.

П.Зоригтбаатар: Иргэдээс сонгогдсон сонгогдсон захирагч Ерөнхий сайдаар захирамжлагдана. Аймгийн Засаг дарга иргэдийн хурлаас нэр дэвшээд Ерөнхий сайд захирамжлагдана. Ингээд Ерөнхий сайдын захирамжлах 2 хот болон захирагч зэрэгцэн оршихоор иймэрхүү юунууд зэрэгцсэн ийм бүтэц бий болох ийм юмнууд байгаа. Тэгээд энийгээ бид нар яаж хийх вэ, чиг үүрэг яаж хуваарилах вэ албан тушаалын тодорхойлолтуудаа яаж хийх вэ гээд бид яриад л байгаа юм л даа. Ерөнхийдөө бас энэ дээр яг шийдтэй тийм чиг хэлчих бас ийм энийг ийш нь тийш нь гэдэг ийм шийд хэлчих бас хүмүүс байхгүй. Бид нар ерөнхийдөө хоорондоо ямар байж болох вэ гэдэг вариант тооцоонуудыг хийж үзээд яваад байгаа юм. Тийм тэгэхээр зэрэг энийг нэг мөр болгохын тулд бид нар энэ хугацаа бас амжихааргүй ийм хугацаа гараад байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Яриад л байгаа юм уу? Шижир гишүүн.

Ө.Шижир: Үзэл баримтлалаас холбоотой 2 юм асуучихъя. Ер нь ингээд хугацааг нь тулгаж оруулж ирээд одоо батлахгүй бол болохгүй гэдэг ийм юм руу энэ Их Хурал 2 дахиа орж байна. Өмнө нь Улс төрийн намын тухай хуулийг оруулж ирээд бас ингээд баталчихсан. Одоо энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг. Тэгээд энэ чинь хэрэгжиж эхлэхээс 14-хөн хоногийн өмнө энэ хуулийг бид нар хэрэгжүүлж чадахгүй нь гэсэн л үндэслэл ярьж байна шүү дээ энгийнээр ярих юм бол. Ийм байж болохгүй л дээ. Тэгвэл Их Хурал байгаад тогтоол гаргаад, хууль батлаад яадаг юм. Тэгвэл та хэд анхнаасаа хугацаагаа хэлдэг болох хэрэгтэй шүү дээ. 28 оноос бид нар хэрэгжүүлдэг больё гэдэг ч юм уу. Эхнийх нь

Хоёрдугаарх нь энэ аягүй сонин юм. Энэ засаг захиргааны нутаг дэвсгэр чинь өөрөө Засгийн газрынхаа бүтцийн байгууллага биз дээ? Тэгээд Засгийн газар нь орон нутагтайгаа зөвшилцөж чадахгүй тодорхойгүй байна гэдэг үндэслэл биччихсэн байх үзэл баримтлал дээр. Энэ яг юу гэсэн үг юм? Нэгдүгээрт бас энийг ойлгохгүй байна.

Хоёрдугаарх нь энэ хэрвээ энийг хойшлуулах юм бол Улсын Их Хурлын 72 дугаар тогтоол уялдаа хангагдана гэчихсэн байх юм. Энэ чинь хангагдаагүй явж байсан бол яагаад 14 хонгийн дотор оруулж ирж байгаа юм? Энэ ямар учиртай тайлбар юм?

Гуравдугаарх нь сая тэр тайлбар дээрээ хил хязгаар эргэлтийн зэргийг тогтоож чадахгүй байна гэж байна. Энэ ямар улс орны хил тогтоох гээд байгаа юм уу? Бид нар хөрш хөрш улсуудтайгаа хилийн цэсээ дахиж ярих гээгүй шүү дээ. Энэ чинь бүтэн туурга тусгаар Монгол Улс орон нутгийнхаа зохион байгуулалт хийх асуудлыг одоо энэ тийм ойлгохгүй байна. Хил хязгаараа тогтоож чадахгүй, эргэлт... хийж чадахгүй байна гэдэг чинь Засгийн газар нь орон нутагтайгаа ажлаа ярьдаггүй юм уу? Тусдаа холбооны улс болчихсон юм уу? Бүүр сая яг тэгж хариуллаа шүү дээ 2 удаа. Эрдэнэбүрэн сайд хариулаад, сая ажлын хэсэг нь тэгж хариулж байна. Тэгээд энэ 3 асуултад надаа хариулт өгөөч.

Ер нь яах вэ ийм л дээ. Энэ хууль хэрвээ хэрвээ Улсын Их Хурлын нэг тогтоолоор ТӨК байгуулах байсан аль бол хэдийн байгуулаад бүх хүмүүсээ 100 авчихсан байгаа шүү. Бараг байгуулсан үед нь, тогтоол гарсан өдөрт нь байгуулаад тэр өдөртөө хүмүүсээ авчихсан байгаа. Тэгтэл ийм чухал хууль дээр ингээд Хот, тосгодын эрх зүйн байдлын тухай хууль дээр бүүр огт ямар ч ажил хийгдээгүй, хөдөлгөөн явагдаагүй ийм байна гэдэг бас арай л хариуцлагагүй л байна л даа.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбүрэн сайд хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Шүүмжлэлийг хүлээж авч байна. Тэгэхдээ энэ бас цаг хугацаа үнэхээр шаардлагатай байгаад байгаа юм. Энэ эдэлбэр газар тогтоох дээр. Олон газар бол өөр өөр саналтай байгаад байгаа. Тэгээд бид нар ерөнхийдөө явж явж энэ ерөнхий төлөвлөгөөнийхөө хилийн дагуу хилээр эдэлбэр газрынхаа хилийг тогтоогоод явъя гэдэг дээр тогтсон зарчмын хувьд. Гэтэл 8 газар бол ерөнхий төлөвлөгөө байхгүй байгаа шинээр байгуулагдах 8 хот тогтоолоор яасан. Энэ ерөнхий төлөвлөгөөнүүдийг маш хурдан хугацаанд хийж дуусгах хэрэгтэй байгаа. Энэ чиглэлээр бол бид нар ингээд ажиллаад явж байгаа.

Түрүүнд манай Сандаг-Очир гишүүн бас хэллээ. Хууль батлагдаад бид нар сонгууль дөхчихсөн байсан тэгээд сонгууль гэж явчхаад нэлээн бас цаг хугацаагаа алдчихсан юм билээ. Тэгээд одоо илүү идэвхтэй ажиллана гэж ингэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүн.

Ө.Шижир: Энэ Засгийн газар нь ажлаа явуулахдаа орон нутагтай зөвшилцөх зэргээр тодорхой болоогүй гэдэг нь яг ямар үндэслэл юм? Би энэ үндэслэлийг нь ерөөсөө ойлгохгүй байгаа юм.

Хоёрдугаарх нь энэ 72 дугаар тогтоолын уялдаа энийг хойшлуулах юм хангагдана гээд байгаа байхгүй юу. Тэгээд одоо хангагдахгүй яваад байгаа юм уу? Тийм, энэ үндэслэл дээр, бүүр үзэл баримтлал дээр нь ингээд биччихсэн байгаа юм. Тэгээд би тэрийг нь л асуугаад байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбүрэн гишүүн 4 номерын микрофон. 4 номер.

П.Зоригтбаатар: Эдэлбэр газрын сая Эрдэнэбүрэн сайд хэлсэн эдэлбэр газрын асуудал хамгийн үндсэн суурь асуудал байгаад байгаа юм л даа. Тэгэхээр би зүгээр жишээгээр хэлье, бодитой жишээгээр. Дархан-Уул аймгийн Хараа голын баруун талын эрэг дээр Ширээ нурууны бас хороолол байгаа. Тэгээд тэр хороолол Сэлэнгэ аймгийн нутаг руу орж ирж байгаа. Орхон аймгийн баруун талын дэнж болон Оросын булгийн орчим нь бол Булганы 2 сумын нутаг руу орж ирж байгаа.

Тэгээд хотын эдэлбэр газар дээр тэр суурьшлын бүсээр тогтоочихоор зэргэлдээ аймгуудынхаа газар нутаг дээр давхацчихаж байгаа юм. Тэрийг бид нар Барилга, хот байгуулалтын яамтай ярихаар ер нь бол хилийн цэсэд нь, аймгийн хилийн цэсэд нь өөрчлөлт орж байж өөрчлөгдөх ёстой гэдэг асуудал яриад бид нар холбогдох аймгуудтай бид нар хилийн цэсийн өөрчлөлт оруулах асуудал иргэдийн хуралд асуудлуудаа оруулъя гээд иргэдийн хурлуудаар санал гаргаад ирэх юм бол бид нар Их Хуралд өргөн барих ийм процесс явах гээд, явах болчихоод цаг хугацаа ороод байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүн.

Ө.Шижир: Үгүй харин тийм. Бид нар ямар 2 улсын хоорондын хил тогтоох гээд байгаа биш дээ. Ямар 2 улсын хоорондын эдэлбэр газар бие бие рүүгээ шилжүүлж авах гээд байгаа биш дээ. Энэ чинь холбооны улс биш биз дээ? Тэгээд нэгэнт энэ Засгийн газар гэж байгаад Засгийн газар нь энэ бүтцээрээ явж байгаад ингээд бүтцээрээ зохион байгуулаад явахад тийм хүндрэлтэй асуудал байдаг юм уу л гэж асуугаад байгаа шүү дээ. Энэ чинь Засгийн газрын бүтэц биз дээ? Бүтцийн чинь нэг хэсэг биз дээ? Тэгж л асуугаад байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? 4 номер.

П.Зоригтбаатар: Засаг даргын Тамгын газар Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтраад ерөнхийдөө дэвсгэр нутгийн хэмжээг одоогийн байдлаар төслийн хэмжээнд тогтоочхоод холбогдох аймгийн ИТХ-д Засаг даргаас өргөн барих, тэгээд иргэдийн хурлаар шийдвэрлэх цаг хугацааны хувьд бол өнгөрсөн оны сүүлээр орон нутгийн иргэдийн сонгууль болсонтой холбогдоод тэр ажил явж чадаагүй. Тэгээд тэрний дараагаар яваад бид нар цаг хугацааны хувьд багтахгүй байгаа учраас л тийм иргэдийн хурлын ший шийдвэр гарч ирж байж Засгийн газар Улсын Их Хуралд шийдвэрийн төсөл өргөн барих юм. Хилийн цэсэд өөрчлөлт орох асуудал.

Ж.Бат-Эрдэнэ: Надаа 1 асуулт байна. Энэ 20 минут хот Үндэсний хороон дээр Алдаржавхлан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа гээд байх юм Эрдэнэбүрэн сайд аа. Энэ Алдаржавхлан гишүүн мөн үү, эсвэл Алдаржавхлан гэдэг өөр хүн юм уу? Нэг.

Хоёрдугаарт хэний тушаалаар, ямар эрх зүйн актаар энэ Засгийн газрын үйл ажиллагаа дотор, гүйцэтгэх засаглал дотор маань энэ Улсын Их Хурлын гишүүн орчихсон явж байгаа юм бэ? Энэ дээр тодруулж өгөөч. Энэ ерөөсөө ойлгомжгүй юм яваад байх юм?

Р.Эрдэнэбүрэн: Энэ Үндэсний хорооны хариулах уу? Үндэсний хорооны бүрэлдэхүүнд 2 Их Хурлын гишүүн ажиллаж байгаа шүү дээ. Лувсанжамц гишүүн, Алдаржавхлан гишүүн 2. Тэгээд өөрсдөө саналаа өгөөд анх Үндэсний хороо байгуулагдахад тийм. Тэгээд Алдаржавхлан гишүүн өөрөө санал тавиад би энэ

ажлыг анх санаачилж ярьж байсан хүн учраас үүгээрээ ажлын хэсэг ахлаад явмаар байна, бэлтгэл ажлыг нь хангамаар байна гэдэг санал тавиад тэгээд ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ тэгээд ийм бантан болж байгаа юм уу хаашаа юм бэ? Энэ чинь юу яриад байгаа юм бэ? Засгийн газрын ажлын хэсгийг Улсын Их Хурлын баталчихсан Улсын Их Хурлын гаргасан хууль дүрмийн дагуу гүйцэтгэх засаглал дотор Улсын Их Хурлын гишүүн орчихсон явж байна гэсэн чинь юу гэсэн үг юм? Тэгээд би хэлээд байна шүү дээ хэний тушаалаар? Үгүй болих хэрэгтэй шүү дээ тэгээд. Ийм юм байна гэж байхгүй шүү дээ. Тэгээд хариуцлага хэн хүлээх юм тэгвэл? Алдаржавхлан гишүүн хүлээх юм уу, эсвэл Засгийн газар хүлээх юм уу? Одоо өнөөдөр оруулж ирж байгаа чинь ийм л асуудал орж ирж байна шүү дээ. Ийм байж болохгүй шүү дээ энэ чинь. Энэ замбараагүй юмаа зогсоох хэрэгтэй.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Батбаатар гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ түгжрэлтэй, дээрээс нь утаатай, хүн амын бөөгнөрөл ихтэй энэ хотод энэ хууль зохицохгүй юм гэдгийг би анхнаасаа хэлж энэний эсрэг байсан. Тэгэхээр ер нь яг хөдөө орон нутагтаа ямар ч тийм үйлчилгээ болон төрийн үйлчилгээ болон бусад нийгмийн болон эдийн засгийн сайн үйлчилгээ үзүүлдэггүй тэр газруудаас бүгдээрээ л хот руу шилжиж байгаа юм. Тэгэнгүүт бүгдийг нь энд ингээд хот гээд энэ чинь бүх дүүргийг хот болгоод, дээрээс нь Эрдэнэт, Дархан бүгдийг нь хот болгоод ингээд явчихлаар бүх төвлөрөл чинь бүгдээрээ наашаа яг энэ төвийн бүс рүү хүрээд ирж байгаа байхгүй юу даа.

Өнгөрсөн 2024 онд 3.3 их наяд төгрөгийн нийт зардалтай байсан хот өнөөдөр жишээ нь энэ хуулийг аваад л 6 их наяд дээр зардалтай байгаа байх. 6.6 их наяд бол баталгаатай. 600 тэрбумаар хэтрүүлнэ. Ингээд 1 дахин зардал чинь ихэсчхэж байгаа юм. Энэ ихсэх тоогоор. Гэтэл жишээ нь орон нутгийн аймгууд 21 аймагт чинь үсрээд л 2 их наядын хөрөнгө оруулалт байж байгаа, зардал байж байгаа. Тэгээд энэ хэрээрээ Улаанбаатар хот руу хөрөнгө оруулалт нь ихдээд тэрний үйлчилгээ нь сайжраад байх тусам хөдөө орон нутаг хөгжихгүй байх тусам энэ хуулийн чиг хэрэгжилт их асар муу болж явах байхгүй юу. Өөрөөр хэлбэл, та нарын тэр утаа, түгжрээ чинь бүгдээрээ бүгдээрээ хэвээрээ л байх болно. Ер нь яаж энд төвлөрлийг сааруулдаг юм бэ гэх дээр бүс бүсэд таталцлын хотуудыг байгуулах замаар шийддэг байхгүй юу. Жишээ нь баруун аймагт Ховд аймаг, наашаа эргээд Хархорин, Эрдэнэт, Дархан уламжлалаараа, тэгээд Даланзадгад, Чойбалсан. Энэ хотуудыг илүү хөгжүүлж тэнд илүү сайн хөрөнгө оруулалтыг хийж, тэнд бүгд ард иргэд хот орохгүйгээр төрийн үйлчилгээ болон бусад нийгмийн бусад үйлчилгээг авсны үр дүнд тэнд сайхан амьдрах, тэндээ асуудлаа шийдэх тэр боломжийг гаргаж байж л энэ төвлөрөл чинь байхгүй болох байхгүй юу дээ.

Дээрээс нь манайх хүн ам цөөтэй, маш том өргөн нутагтай энэ бүс нутаг. Тэгж ярих юм бол аймаг дотор таталцлын сумуудтай байх ёстой байхгүй юу даа. Заавал аймгийн төв орохгүйгээр асуудлаа шийддэг сумуудтай байх ёстой. Ингэж байж бид нар тэр өргөн нутаг дэвсгэрийнхээ тэр ард иргэдийг сайхан амьдруулах,

тэр Улаанбаатар хот руу хэт хэтэрхий төвлөрлийг бий болгохгүй байх энэ зүйлүүдийг бүгдийг нь хийх ёстой байсан.

Гэтэл харамсалтай нь энийг хүчиндээд л хийсэн. Одоо тэгээд л энэ чинь зөндөө юмнууд араасаа дагуулж байгаа. Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтууд хэлж байна шүү дээ. 1-хэн жилийн дотор 1 дахин өсөж байна шүү дээ. 3.3 их наяд байсан бол 6 их наядын зардалтай болчихсон байгаа. Хөрөнгө оруулалт бүгд ороод. Ингэж явах дээр чинь наадах та нарын энэ Улаанбаатар хот руу шилжих тэр шилжилт хөдөлгөөн чинь улам ихсээд та нарын тэр зориод байгаа тэр төвлөрлийг багасгах энэ бүх зүйл чинь бүгдээрээ л ерөөсөө ямар ч үр дүнгүй болох байхгүй юу даа. Хайран их хөрөнгүүд 6.6 их наяд, 6 их наяд төгрөг тиймээ энэ зардал чинь ерөөсөө тэгээд л та нар ажиллаад байдаг, хийгээд байдаг, зүтгээд байдаг. Гэтэл нөгөө төвлөрлийг чинь авчраад улам нэмэгдүүлэх тэр хотыг төвийн бүсэд хэтэрхий олноор бий болгосны үр дүнд энэ төвлөрөл чинь хэтрээд тэрнээсээ болоод та нарын тэр тэмцэл чинь, зүтгэл чинь ямар ч үр дүнгүй болно гэдгийг би хэлээд байгаа юм.

Тийм учраас 1 жилээр хойшлуулж байгаа нь зөв байна. Дахиад бүүр тэр чигээрээ энэ хууль нь хэрэгжихгүй дуусаасай гэж би бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн үг хэлнэ.

Ц.Сандаг-Очир: Би эсрэг байр суурьтай байгаа. Энэ 1 жилээр хойшлуулах шалтаг, шалтгаан байхгүй. Хуулийг ингээд газар нутаг хилийн цэсээс болоод, Дархан, Эрдэнэтээс болоод, ойлголцоогүйгээсээ болоод, цэг тэмдэгтэй хилийн асуудлаа, маргааны асуудлаа шийдээгүйгээс болоод энэ хуулийг хойшлуулах шаардлагагүй гэж бодож байна. Тэгвэл боломжтой газраас нь эхлээч. Ямар ч газар нутгийн маргаангүй, хил зэс маргаангүй байгаа энэ Дархан, Эрдэнэт гээд тэр 200, 300км-т байгаа аймгаас чинь гадна энэ хаяанд байгаа 40км-т-т байгаа Налайх, 130км-т байгаа Багануур хилийн цэсийн ямар ч маргаангүй, бололцоотой байгаа энэ 2 дүүргээс эхлээч энэ ажлыг эхлээч. Цаашдаа тэр үнэхээр бололцоотой, боломжтой байна гэдэг нь харагдаад эхлэхээр хүссэн, хүсээгүй наад Дархан, Эрдэнэтийнхэн чинь өөрсдөө зохион байгуулалтад орж ирэх байхгүй юу. Тэрнээс хүчээр газар нутгийн асуудлыг нь шийдэх гэхээр наад ард иргэдийн маргааны асуудал болно.

Тийм учраас ажлаа эхлүүлье гэвэл, энэ хуулийг хойшлуулахгүйгээр эхлүүлье гэвэл бололцоот, боломжтой энэ маргаангүй байгаа, бололцоотой байгаа энэ 2 хотуудаас нь эхэлбэл наад хуулийн чинь ажлыг заавал хойшлуулах шаардлага, би үгээ хэлчихье Пүрэвдорж гишүүнээ. Тийм учраас наадхаа энэ хуулийг хэрэгжүүлэх хугацаагаа хойшлуулахгүйгээр бололцоотой газраас нь эхлүүлээд явах бололцоо боломж байгаа шүү гэдгийг та нар тэр талаас нь хараач. Зөвхөн Дархан Эрдэнэтийг харчхаад л газар нутгийн маргаантай гээд л өнөөдөр бүхэл бүтэн энэ хуулийг хойшлуулж, наадах чинь яг хойшилно гэвэл жилийн дараа та нар бэлтгэл ажил ахиад л хангагдаагүй гээд л оруулж ирнэ. Би сайн мэдэж байна.

Тийм учраас та нар хүссэн, хүсээгүй энэ хуулийг хэрэгжүүлэх ёстой Засгийн газар. Хуулийг буруу тайлбарлаад сууж байх юм та нар. Та нар хуулийг тайлбарлахгүй шүү дээ. Тэр маргаантай, Үндсэн хуулийн зөрчилтэй байгаа бол Цэцдээ л гарга л даа тэр гомдлоо гаргаад. Тэгээд болсон, болоогүй буруу, зөрүү гэж байгаа бол тэрийгээ тэр холбогдох газарт нь гаргая. Үгүй бол та нар хуулиа

хэрэгжүүлээд явах, бэлтгэл ажлаа хангаад явах, батлагдсан өдрөөс нь авхуулаад хуулиа хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаад явах ёстой шүү дээ. Тэгээд ажлаа хийгээгүй байж байж хуулийг хойшлуул гэж ингэж оруулж ирдэг чинь зарчмын хувьд буруу байгаа юм л гэж хэлэх гэж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн үг хэлнэ.

Б.Батбаатар: Ардын нам, Ардчилсан намын гишүүд шиг улс төрийн 118-ын бүдүүн бүлэг байгуулчихсан хүмүүсийн хоорондох асуудал байгаад байгаа юм. Хэчнээн бүтээмжийн менежер, хяналтын менежер, ямар албан тушаалууд, ямар төсөв мөнгө, татварын мөнгийг яаж, хэрхэн бие биедээ хуваарилж байгаа энэ асуудалтайгаа холбоотойгоор хуулийг хойшлуулах тухай ярьж байна л гэж ойлгож байгаа. Нэгэнт баталчихсан хуулиа нэг бол энэ Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй, хуулийн хэрэгжилтийг Их Хурлын өмнө тайлагнах ч үүрэгтэй. Тэгээд энэ баталчихсан хуулиа хэрэгжүүлэхгүй байна гэдэг нь бие биедээ гаргаж өгөх бялууны асуудлаа тохирч чадахгүйдээ болоод байгаа юм байна гэж улс төрийн утгаар нь ойлгож байгаа юм.

Нөгөө талдаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж хууль хэрэгжүүлж чадахгүй байгаа бол, нэг бол хууль нь хэрэгжих боломжгүй байгаа бол энэ хуулиа өөрчлөх зам руугаа орох ёстой. Хуулиа хэрэгжүүлж чадаж байгаа бол, хэрэгжих ёстой хуулийг хэрэгжүүлж чадахгүй байгаа бол хариуцлагыг нь тооцоод ажлаа хийж чаддаггүй хүмүүсээ өөрчлөх хэрэгтэй.

Засгийн газар өөрөө хууль хэрэгжүүлж чадахгүй байгаа гэдгээ илэрхийлж болсон болоогүй ямар үндэслэлүүд тавиад тэр нь болохоор Их Хурлын гишүүд Үндсэн хуулийн асуудал дээр энэ хууль дээр өөр өөр ойлголттой байгаа юм, сурч амжаагүй юм байгаа юм. Бид нар ойлгуулж өгчхөөд дараа нь хуулиа хэрэгжүүлэх гэдэг шалтгийг Байнгын хорооны хурал дээр ярьж байдаг ямар учир байдаг юм. Их Хурлын гишүүдийн зөрүүтэй ойлголт энэ хуулийг хэрэгжүүлэхэд хэцүү байгаа юм гэж. Их Хурлын гишүүд хууль хэрэгжүүлэх үүрэг Засгийн газар шиг хүлээдэггүй шүү дээ. Хууль хэрэгжүүлэх үүрэгтэй Засгийн газрын төлөөлөл нь Байнгын хорооны хурал дээр орж ирчхээд Их Хурлын гишүүд хуулийн талаар Үндсэн хуулийн зөрүүтэй ойлголттой байгаа учир бид хэрэгжүүлэхгүй байгаа юм гэж ярьдаг. Нөгөө нэг утга нь болохоор бодит жишээ гэж ярьж байгаад хэдэн орон сууц баригдсаныг зааж хэлж байгаад орон нутгийн нутгийн удирдлагын засаг захиргааны нэгж рүүгээ заачихдаг. Энэ чинь ерөнхийдөө хуулийн хэрэгжилтийг хариуцах хариуцлагын асуудлаасаа зугтаж байгаад хэлбэр шүү дээ.

Нэг бол хуулиа хэрэгжүүлээд нэг бол энэ хуулийг хэрэгжүүлж болохгүй хуулийг өмнөх Их Хурал баталчихсан юм байна. Хэрэгжүүлэх боломжгүй юм байна, Үндсэн хуулийн зөрчил үүсэж байна. Үндсэн хуулийн зөрчилтэй хуулийг Засгийн газар хэрэгжүүлэхгүй гэдэг шалтгаанаа хэлээд Цэцэд хандаад, үгүй бол энэ хуулиа өөрчилж гээд эргээд Их Хурал руу авч орж ирэх хэрэгтэй шүү дээ. Үгүй бол тэр хугацаанд нь багтаж хийх ёстой ажлыг хийх ёстой. Татвар төлөгчдийн мөнгөөр цалинжиж байгаа. Нөгөө талдаа бас тодорхой эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбар: Энэ хуулийн хэрэгжилтийг хангахад хараахан болоогүй гэж үзээд байгаа. Яагаад гэхээр одоо Их Хурал дээр шинэ Үндсэн хуулийн хүрээнд 126

гишүүн хэд хэдэн асуудлуудыг хөндөж ярьж гэж ярьж байгаа. Жишээлбэл, эдийн засгийн томоохон макро бодлогын хүрээнд 2050-ийнхаа асуудлыг эргэж харъя, салхи оруулъя, үүссэн нөхцөл байдалтайгаа уялдуулъя гэж байгаа. Дээрээс нь энэ төсвийн суурь тогтолцоогоо эргээд харъя гээд бас ажлын хэсэг гараад явж байгаа. Хөгжлийн бодлого төлөвлөлт удирдлагын тухай хуулийн аргачлал энэ эрх зүйн орчныхоо шинэчлэлийн асуудлыг хөндье өө гээд энэ Байнгын хороон дээр гараад явж байгаа.

Дээрээс нь энэ Байнгын хороон дээр Байнгын хорооны дарга ахалсан Улаанбаатар 2040 ажлын хэсэг явж байгаа. Энэ бол шууд энэ хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой. Дээрээс нь зөвхөн хотын удирдлага зохион байгуулалтын төлөвлөлт гэхээсээ илүү орон нутаг бас их орхичхоод байгаа юм. Жишээлбэл, манай Чойбалсан хотын асуудал яах вэ? Маш олон сумууд татан буугдах шаардлага үүсчихсэн байгаа. Үндсэн хуулийн тэр маргаантай асуудлыг би нэг л сайн ойлгохгүй байгаад байгаа юм. Маргаан чухам юундаа байгаад байгаа юм? Хаашдаа Үндсэн хуулиар Улсын Их Хурлын халдашгүй бүрэн эрх чинь яг энэ асуудал орчихсон байгаад байгаа.

Тэгэхээр хойшлуулаад ер нь томоохон зургаар харъя. Тэгээд Бат-Эрдэнэ даргаа Төрийн байгуулалтын байнгын хороо энэ дээр бүүр онцгойлон хэдүүлээ ажилламаар байна. Зөвхөн энэ хотын асуудлыг 14 хуваахдаа биш улс орныхоо хэмжээнд харчихмаар байгаад байгаа юм. Тэгээд бид нар чинь сонгуулиа бүсчилсэн хөгжлийн суурь зарчмыг бий болгох гэж л явуулсан шүү дээ. Зарим шаардлагагүй аймгуудыг ч гэсэн татан буулгаад бусадтайгаа нэгтгэх замаар шийдчихмээр байгаа байхгүй юу. Тэгэхээр иймэрхүү иймэрхүү үндэслэлээр энэ хуулийн хэрэгжилтийг хойшлуулаад.

Харин цаашдаа авч хэрэгжүүлэх арга хэмжээ гол бодлогын концепцыг манай Байнгын хороо манлайлаад л нэлээн ажилламаар санагдаад байгаа юм. Ийм саналтай байна дарга.

Ж.Бат-Эрдэнэ: Би бас санал нэг байна. Ер нь бол Улаанбаатар хотын 2040 ерөнхий төлөвлөгөө хэлэлцэгдэж байгаа. Тэгээд энэтэй уялдуулаад ер нь асуудлыг нэлээн энэ Номтойбаяр гишүүний хэлсэнчлэн асуудлыг нэлээн томхон хүрээнд нь харвал яасан юм бэ гэсэн ийм саналтай байж байгаа. Тэр тусмаа Улсын Их Хурлын 72 дугаар тогтоол байж байгаа. Улаанбаатар хотыг 14 жижиг хот болгох гээд байгаа тийм үү? Миний хувьд энийг бас эргэж харах нь зүйтэй байх гэж бодож байгаа. Одоо яг энэ 2040-тэйгээ уялдуулаад энэ 14 хот байх ёстой юм уу, байхгүй ёстой юм уу? Зөв байсан юм уу, үгүй байсан юм уу гэдэг дээр бас судалгаа хийгээд үзэх нь зүйтэй болов уу гэсэн ийм саналтай байгаа юм.

Тийм болохоор энэ өнөөдрийн орж ирсэн энэ хуулийг бол хойшлуулах нь зүйтэй гэж миний хувьд бол хуулийн төслийг бол дэмжиж байгаа юм.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Энэ хуулийн 35.8-д заасны дагуу хуралдааныг явуулсны дараа Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна гэж байгаа.

Ингээд санал хураалт Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

15 гишүүнээс 8 гишүүн дэмжиж ,санал дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

15 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

15 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хийж дууслаа.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Хэн танилцуулах юм айн санал, дүгнэлт? Зулпхар гишүүн унших санал, дүгнэлт чуулган дээр Зулпхар гишүүн танилцуулна.

Саяын асуудалтай холбоотойгоор тэр Засгийн газрын бүрэлдэхүүнд орж ажлын хэсгийг ахалж байгаа Улсын Их Хурлын гишүүд байгаа шүү. Энийг ер нь болих хэрэгтэй шүү. Тодорхой асуудал юу яахгүй бол энэ чинь хууль тогтоох байгууллага гүйцэтгэх засаглал руугаа орж асуудал шийдэж, бас гардаж ажиллана гэж юу байсан юм бэ. Хэрвээ тийм юм байгаа бол гүйцэтгэх засаглалдаа орж ажиллах хэрэгтэй шүү дээ. Тийм. Улсын Их Хурлын гишүүнээ өгдөг юм уу, яадаг юм. Тэгчихсэн. Энэ дээр анхаарах хэрэгтэй шүү. Дараагийн асуудалдаа оръё.

14.16 цаг

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай байдлын талаарх 24 дэх илтгэл.

Ажлын хэсгийг оруулъя. Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид танилцуулна.

Ажлын хэсгийг оруулж ирье. 4 номерын микро микрофон.

Д.Сүнжид: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх 24 дэх илтгэлийн 2 сэдвийг Улсын Их Хурлын даргаас үүрэг болгосны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулъя.1 дүгээр сэдэв 2024 оны сонгуулийн үйл ажиллагаа, сонгох, сонгогдох эрх гэдэг сэдэв бий.

Энэ сэдвийн хүрээнд 4 судалгааг Хүний эрхийн Үндэсний комиссоос хийлгэсэн. Улсын Их Хурлын 9 дэх удаагийн ээлжит сонгуулийн үйл явцад дүн шинжилгээ хийлгэсэн. Мөн 9 дэх удаагийн аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн үйл явцад дүн шинжилгээ, мониторинг хийлгэлээ.

Түүнээс гадна энэ сонгуулийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулсан дүн шинжилгээ хийсэн. Цахим ялгаварлан гадуурхалд өртөж байгаа байдал, нэр төрийг гутаах нөхцөл байдал гээд энэ кэйс судалгаа хийлгэсэн юм. Энэ 4 судалгаандаа үндэслээд энэхүү бүлгийг боловсруулсан. Түүнээс гадна Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо гээд асуудал хариуцсан 9 байгууллагаас мэдээлэл, статистик тоо баримтыг авсан. Ирүүлсэн гомдол, мэдээлэл, хянан шийдвэрлэсэн байдалд мөн дүн шинжилгээ хийсэн.

Гол дүгнэлт хийсэн асуудал нь Иргэний болон улс төрийн эрхийн фактаар 4 зарчмыг сонгууль, ардчилсан сонгууль баримтлах ёстой гэж заасан байдаг. Үүнийг бас Үндсэн хуульд заасан байдаг. Энэхүү бүх нийтээрээ оролцож сонгууль өгөх зарчим, тэгш эрхийн зарчим, чөлөөтэй байх зарчим, нууцаар санал өгөх зарчим хэрхэн хангаж байгаа вэ гэдэгт энэ нэгдүгээр сэдвийн хүрээнд дүн шинжилгээ хийлээ. Ингээд үзэхээр нэгдүгээрт эрх зүйн зохицуулалтын хувьд бид нар 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хийсэн. Тэгэхдээ аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн зохицуулалтыг өөрийнх нь онцлогийг тусгасан байдлаар бас шинэчлэн найруулах шаардлагатай байна гэдгийг дүгнэсэн. Ер нь 2 сонгуулийн хууль ер нь бие биеэ хуулбарласан байдалтай маш адилхан зохион байгуулагдсан. Энэ нь өөрөө зорилгоо хангахгүй байна гэдэг эхний дүгнэлт байна.

Бүх нийтийн байх зарчим дээр 2005 онд Хүний эрийн Үндэсний комисс 5 дахь, 3 дахь өөрийнхөө илтгэлд бас дүгнэж байсан юм байна. Тэр үедээ юу гэж дүгнэж байсан бэ гэхээр бүх нийтээр байх зарчимд оюутан, шилжин суурьшигчид, хөдөө орон нутагт түр амьдарч байгаа хүмүүс сүүлийн үед нэмэгдээд дэд бүтэц, уул уурхай бүтээн байгуулалтад ажиллаж байгаа ажилтнууд ба өөрийнхөө албаны үүргээ гүйцэтгэж байх явцдаа тухайн оршин суугаа харьяаллаасаа өөр газар амьдарч байгаа иргэдийн хувьд сонгох эрхээ эдэлж чадахгүй байна гэдэг дүгнэлтийг хийсэн. Тэгэхээр бид нар энэ дээр нэгэнт цахимаар ийм сонгууль өгөх, урьдчилсан сонгууль өгөх, шуудангаар сонгууль өгөх олон хувилбарыг олон улсад, бусад улсад хэрэгжүүлээд, нэгэнт төлөвшчихсөн ийм нөхцөл байдалд энэ иргэдийн сонгох эрхийг эдлүүлэх боломжийг хуулиар олгох нь зүйтэй гээд.

Хоёрт нь тэгш байдлын зарчим байгаа. Тэгш байдлын зарчим дээр хамгийн гол нь мандатын тоо буюу сонгогчийн тоог жигд төлөөлж чадаж байгаа юу гэдэг асуултад хариулт өгөх ёстой. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль дээр хүн амын тоо, сонгогчдын улсын дундаж сонгогчдын тоог харгалзана гэж байгаа боловч яг бодит байдал дээр мандатын тойрог хуваасан байдлыг аваад үзэхээр маш их зөрүүтэй ийм тоонууд байна.

Тэгэхээр энэ дээр 1 саналын эзлэгч нь сонгогчийн төл төлөх байдал гэдэг энэ жинг харьцуулан цаашид сонгуулийн тойргийг тогтоохдоо Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас зөвлөсөнчлөн 10-15 хувийн хэлбэлзэлтэйгээр энэ сонгогчдын тоог тойрогт хуваахдаа үндэслэх нь зүйтэй байна гэдэг дүгнэлтийг хийлээ.

Чөлөөтэй байх зарчмын хүрээнд сонгуулийн сурталчилгааны хугацаа байна. Энэ хугацааг тойргийг томсгосон үед энэ 17 хоногийн сонгуулийн сурталчилгааны хугацаа сонгогчдын мэдэх эрхээ хэрэгжүүлэхэд мэдэхэд тэр хөтөлбөр нэр дэвшигчийн талаар танилцах, мэдэх, сонголтоо хийх үүднээс мэдээлэлтэй бүрэн танилцахад хангалтгүй байна. Нөгөө талаас нэр дэвшигч өөрийгөө таниулах, мэдүүлэх, сурталчлахад хангалтгүй байна. Тэгэхээр үүнийг бас цаашдаа анхаарах нь зүйтэй юм байна.

Түүнээс гадна мандатын тоо Үндсэн хуулийн цэцийн бас сүүлд дүгнэлт санал гарсан. Мандатын тоотой тэнцүү дугуйлахыг Улсын Их Хурлын сонгуулийн тухайд шаардаж байгаа нь чөлөөтэй байх зарчимд бас нөлөөлж байна гэж дүгнэлээ. Саналаа нууцаар гаргах зарчмын тухайд стандартыг л хэрэгжүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлэх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусдын тусламжтайгаар зөөврийн хайрцгаар саналаа өгөх үед энэ дээр саналаа нууцаар өгөх боломжийг нь хангах ёстой юм байна.

Хоёрт нь 20 санал авах байранд 20-иод санал авах байранд гэрт зохион байгуулсан. Тэгэхээр монгол гэр зохион байгуулахаар зай талбайн стандартыг хангах боломж хомс байдаг учраас зайндаа хавчигддаг учраас энэ дээр бас бусдын саналыг харах боломжтой гэдэг ийм асуудлууд бас гарч байгаа.

Дараагийн ээлжид 4 дэх дүгнэлт энэ сонгуулийн зардалтай холбоотой сонгуулийн зардлыг өндөр тогтоочихсон. Хуулиараа сонгуулийн зардлыг илүү багасгана, боломжийг олгоно гэсэн боловч яг Үндэсний аудитын газраас тогтоочихсон сонгуулийн зардал өнгөрсөн 24 оны сонгуулийн хувьд өндөр байлаа. Ингэхээр сонгуулийн зардал өндөр болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүд, бусад энэ амьжиргааны баталгаажих түвшин, орлоготой хамааралтайгаар бүх иргэдээс нэр дэвших ийм боломжийг хязгаарлах үндсэн ийм хүчин зүйл болж байна гэдгийг дүгнэсэн.

Гомдол, маргаан шийдвэрлэлтийг эцэст нь аваад үзэхээр нийтдээ 2600 гомдол аймаг, нийслэл, сум, дүүргийн Улсын Их Хурлын сонгуулийн талаар иржээ. 90 хувь нь цагдаагийн байгууллагатай холбоотой. Өөрөөр хэлбэл, нэр төрийг гутаасан, худлаа мэдээлэл тараасан, самбарыг устгасан, эд хөрөнгийг сүйтгэсэн, мөнгө тараасан, хууль бусаар сонгуульд нөлөөлөхийг завдсан гээд ийм асуудлууд ихэнх нь ирж байгаа. Тэгээд цагдаагийн байгууллагын энэ хүлээн авч шийдвэрлэсэн гомдлын 90 хувь нь хэрэгсэхгүй болгосон. Үлдсэн 10 хувьд нь л асуудлыг хэрэг бүртгэлтийг нээгээд, үүсгээд цаашаа асуудлыг шийдвэрлэсэн ийм дүр зурагтай захиргааны хэргийн шүүхэд 6 нэхэмжлэл очсон. 5 нь цаг тухайдаа хангагдсан, 1 нь яг араас нь цаг хугацааны хувьд хоцрогдолтой ингэж гарч байгаа ийм байна. Ийм нөхцөл байдалд ерөнхийлөн дүгнэвэл ийм нөхцөл байдлуудыг дүгнээд нийтдээ 7 саналыг Улсын Их Хурлын тогтоолд шийдүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

Нэгдүгээрт нь Монгол Улсын Үндсэн хууль олон улсын хүний эрхийн гэрээ конвенцод заасан сонгуулийн үндсэн зарчимд нийцүүлээд сонгуулийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн зөрчил, хийдлийг арилгах хууль тогтоомжийн үр дагаврыг үнэлж, үр дүнд тулгуурлан процедур, механизм, хугацаа, хариуцлагын талаарх хууль тогтоомжийн зохицуулалтыг өөрчлөх гээд эхний санал ер нь хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулаач гэдэг санал дунд нь ямар хуулийн зүйл заалт вэ гэдэг тодорхой саналуудыг бүлгийн хүрээнд нь бүгд нь дүгнэсэн.

Хоёр дахь нь хөгжлийн бэрхшээлтэй гадаад улсад амьдарч байгаа, байнгын оршин суугаа газраас тухайн үед өөр газар амьдарч байгаа иргэд, оюутан, суралцагчид, төрийн албан хаагчид, уртын ээлжээр ажиллаж байгаа ажилтнууд зэрэг сонгогчдын саналаа өгөх боломжийг нь хуулиар нээх.

Гуравт, мандатын тоонд ногдох тойргийн сонгогчдын тооны хэт зөрүүтэй байдлыг арилгах.

Дөрөвт нь сонгуулийн сурталчилгааны хугацааг бодитой тогтоох сурталчилгааны хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, түүнээс гадна сонгогчдын боловсролыг дээшлүүлэх ийм хөтөлбөрийг бий болгох төсөвлөлтийг нь хийх, сонгуулийн үеийн статистикийн нэгдсэн байдлаар бүрдүүлэх.

Тавт нь сонгуулийн зардлыг бууруулах, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, залуучууд зэрэг нийгмийн олон бүлгээс сонгуульд нэр дэвших боломжийг дэмжих түр тусгай арга хэмжээг хуулиар тодорхойлох, батлагдчихсан сонгуулийн хууль тогтоомж, дүрэм журам, эрх зүйн хэмжээний хэрэгжилтийг нь хангуулах, стандартыг сахиулах, хяналт тавих, холбогдох арга хэмжээ авах.

Сүүлд нь, долоод нь сонгуулийн гомдол, маргааныг үр дүнтэй шийдвэрлэх, үр нөлөөтэй хариуцлага тооцох, зөрчигдсөн эрхийг бодитой сэргээх тогтолцоог бүрдүүлэх гэдэг ийм саналыг 1 дүгээр бүлгийн хүрээнд Хүний эрхийн Үндэсний комиссоос гаргасан болно.

1 дүгээр бүлгийг танилцуулж дууслаа. 2 дугаар бүлгийг Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудлыг хариуцдаг Дондов гишүүн танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерын микрофон.

С.Дондов: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хүний эрх хамгаалагчийн талаар Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд жил бүрийн хүний эрхийн хамгаалагчийн талаарх нөхцөл байдлыг Улсын Их Хуралд илтгэнэ гэж заасан. Үүний дагуу бол Хүний эрхийн Үндэсний комиссын энэ илтгэлийн 2 дахь бүлэгт бол хүний эрхийн хамгаалагчийн гол бүрэлдэхүүн хэсэг болох өмгөөлөгч, сэтгүүлчдийн өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ гэсэн асуудлаар судалгаа хийлээ.

Мөн Хүний эрхийн Үндэсний комисст ирсэн гомдлууд, мөн шүүхээр шийдэгдсэн тестүүдэд анализ хийх, мөн зарим сэтгүүлчдийн үйл ажиллагаа биечлэн Хүний эрхийн Үндэсний комиссоос дүгнэлт гаргаж ажилласны хувьд эдгээр материалуудад тулгуурлан сэтгүүлчдийн өнөөгийн нөхцөл байдлыг өнөөдөр ярина гэж ойлгож байгаа. Өмгөөлөгчдийн асуудлыг бол Хууль зүйн байнгын хороон дээр ярина гэж ингэж ойлгосон.

Ингээд сэтгүүлчдийн үндсэндээ энэ шалтгаанд 430 орчим ийм сэтгүүлчид бол оролцсон. Сэтгүүлчдийн өөрсдийнх нь санаа оноо бол нэгдүгээрт ерөөсөө улс төрийн хараат нөхцөл байдал бол сэтгүүлчид илүү их нөлөөлж байна.

Хоёрдугаарт бол бид нар эдийн засгийн хувьд төдийлөн тийм хараат бус байж чадахгүй байна.

Гуравдугаарт бол л ер нь сэтгэл санааны болоод бусад ийм гаднын хүчин зүйлүүдэд, хүчирхийлэлд өртөх маяг бол илүү их байна. Мөн сэтгүүлчдийг хууль бусаар цагдан хорих, мөн ял шийтгэл эдлүүлэх явдал бол түгээмэл болж байгаа нь сэтгүүлчдийн үзэл бодлоо илэрхийлэх, нийтийн мэдэх эрхийг хангахад ихээхэн төвөг биш бэрхшээл учруулж байна гэсэн ийм гол санаануудыг гаргасан.

Үүнтэй уялдуулаад бид үндсэндээ хүний эрх хамгаалагч сэтгүүлчийн талаар Улсын Их Хуралд бол 9 саналыг бэлтгэж оруулсан байгаа. Үүний бол үндсэндээ 6 санал бол хуульд өөрчлөлт оруулах, тодорхой хэмжээнд бодлогын хувьд сэтгүүлчдийн хувьд анхаарч үзвэл зохих асуудлууд байгаа. 3 асуудал бол явцын дунд хэрэгжих боломжтой. Энэ бодитоор хэрэгжвэл сэтгүүлчийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд бол бас их хувь нэмэр болно гэж ингэж үзсэн.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг 1998 онд батлаад хэрэгжилт ингээд явагдсан ч гэсэн төдийлөн хэрэгжилт хангалтгүй. Энэ бол сэтгүүлчдийн чухал хэвлэлийн эрх чөлөөг багтааж чадсан ийм чухал хууль боловч мэдээллийн эх сурвалжаа нууцлах, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах, нийтийн мэдэх эрхийг хангахад бол хангалттай биш байна.

Тийм учраас олон улсын хэмжээнд манайх сэтгүүлчдийн эзлэх байр сууриараа бол нэлээн доогуур үнэлэгдсэн, доогуур гэж хэлэхдээ бүүр муу гэсэн үнэлгээг авсан байгаа. Тийм учраас сэтгүүлчдийн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг олон улсын стандартад нийцүүлж, мөн сэтгүүлчдийн өөрийнх нь яг бодит амьдрал, бодит нөхцөл байдалд тулгуурласан, зөвхөн сэтгүүлчид гэхгүй энэ нийтийн мэдэх эрхийг хангах ийм чухал мэргэжил учраас олон нийтийн санаа бодлыг илүү түлхүү авсан ийм хуулийг батлан гаргах нь их чухал гэж ингэж үзсэн.

Хоёрдугаарт бол Эрүүгийн хуулийн 13, 14 гээд ийм зүйл байгаа иргэний нэр төрийн алдар хүндийн талаарх хуулийн зохицуулалтыг санаатайгаар худал мэдээлэл тараах болон сэтгүүлч мэргэжлийн алдаа гаргах гэсэн энэ ойлголтыг ялгаж зохицуулах явдал бол хамгийн чухал байна. Сэтгүүлчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бол илүү нэгдүгээрт тавих шаардлагатай байна гэж бодсон, үзсэн.

Гуравдугаарт бол олон нийтэд үйлчлэх зорилго бүхий хамтын хэвлэл мэдээллийн ашгийн төлөө бусад хуулийн этгээдийг байгуулж, түүний үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох. Ингэхдээ төрөөс шууд хараат байдлаар санхүүжилт авах арга замаас зайлсхийж, өрсөлдөөнд суурилсан шударга зохицуулалт хийх боломжийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар зохицуулах шаардлагатай гэсэн саналыг оруулсан юм.

Энэ нь яагаад ийм санал оруулж байна вэ гээд тэгэхээр зэрэг ер нь алслагдмал дүүрэгт байгаа, хөдөө орон нутагт байгаа иргэдийн дуу хоолой бол бас төдийлөн сайн гарч ирж чадахгүй байна. Тийм учраас энийг бол олон улсын зөвлөхүүдийн зөвлөсөн, мөн мэргэжлийн сэтгүүлчдийн өөрсдийнх нь дундаас гаргасан ийм санал учраас энийг харгалзан үзэх нь зөв өө гэж ингэж үзсэн.

Мөн редакцын хараат бус байдлыг хангасан зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн хуульчлах явдал чухал байна. Сэтгүүлч мэргэжлийн үйл

ажиллагааны хүрээнд ихэвчлэн хэрэгжүүлж байгаа Иргэний хуулийн 21 дүгээр зүйл, заалт гээд байгаа. 21.2-т бол иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан этгээд түүнийхээ үнэн, зөвийг өөрөө нотлох гэсэн ийм заалт байгаа. Үүний нэг тал сэтгүүлч хэрвээ байгаа бол хариуцагч тал нь сэтгүүлч эх сурвалжийг хамгаалах зорилгоор нотлох баримт гаргаж өгөх үүргээс чөлөөлж болох бүхий агуулга бүхий ийм заалтыг Иргэний хуульд оруулах нь чухал байна гэсэн ийм заалтууд бол хуульд өөрчлөлт орох ийм чухал заалтууд гэж ингэж үзсэн.

Бодлогын явцад хэрэгжих ийм 3 санал байна гэж ингэж үзэж байгаа. Тэр нь бол Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1.6-д бол төрийн байгууллага болон хуулийн этгээд аж ахуйн нэгж дотоод журамдаа хүний нэр хамгаалагчийн үйл ажиллагааг дэмжсэн үйл ажиллагааг нь тайван явуулах боломжийг бүрдүүлсэн ийм агуулга бүхий заалтыг дотоод журамдаа оруулна гэж ингэж заасан учраас энийг бол сэтгүүлчдийн байгууллагууд дотоод журамдаа оруулах явдал бол чухал байна гэсэн энэ заалтыг оруулсан.

Гурав дахь 1 чухал заалт нь явцын дунд хэрэгжих заалт бол Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн байгууллагууд сэтгүүлчдийн аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх эрсдэл тохиолдсон үед үнэлгээ хийж нөхцөл байдлыг бодитоор үнэлэх явдал бол чухал байна гэсэн ийм 3 заалтыг бол бодлогын явцад хэрэгжих юм, явцын дунд хэрэгжих юм. Наад 6 санал нь хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал байна гэсэн ийм саналыг оруулсан. 2 дугаар бүлэг танилцуулж дууслаа.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дүгээр илтгэлийн сонгох, сонгогдох эрх болон сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулгыг сонслоо.

Энэ танилцуулгатай уялдуулаад холбогдуулаад асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Баярмаа гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүн, Зулпхар гишүүн. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Баярлалаа тайланг сонслоо. Би 2 зүйл тодруулах гээд энэ танилцуулга дээр хууль тогтоомжийн хүрээнд 8 санал гээд 2 санал гарсан байна л даа. Нэгийг нь сайн ойлгохгүй байгаа учраас нарийн тодруулмаар байна. Хорих ял эдэлж буй Монгол Улсын иргэн гээд ийм санал байгаад байгаа юм. Энэ хорих ял эдэлж буй иргэнд сонгуулийн эрх олгох тухай асуудал юм уу, ямар учиртай юм?

Хоёр дахь нэг зүйл бол энэ Улсын Их Хуралд суудалгүй намуудад санхүүжилт олгох гээд ийм санал гаргасан шүү дээ. 35 байна уу, 36 улсын улс төрийн нам байгаа юм. Тэгээд тэр намуудаас чинь үндсэндээ 4 нам бол Улсын Их Хуралд суудалтай, 1 эвсэл суудалтай л байгаа шүү дээ. Тэгэхээр бусад намуудад санхүүжилт олгохтой холбоотой асуудлыг та бүхэн бас хөндөж байгаа юм байна шүү дээ. Энийг ямар ямар үндэслэлээр ингэж гаргаж ирсэн, тэгээд энэ яаж олохтой холбоотой бас та бүхэн зохих түвшний судалгаа байгаа байх? Тэрийг сонсьё гэсэн. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаарай

Д.Сүнжид: Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Сүнжид. Зулпхар гишүүний эхний асуултад нь хариулъя. Хорих ял эдэлж буй хүмүүст сонгох эрхийг 3 янзаар улс орнууд зохицуулж байна. Зарим нь бүрэн өгдөг, зарим нь огт бүрэн хаадаг, зарим нь их хэсэгчлэн өгдөг гээд. Тэгэхээр нийтдээ бид нар хорих ял эдэлж байгаа хүмүүсийн тоог аваад үзэхээр 4700 хувь хүн байна. Эндээс 2 жилийн дотор суллагдах магадлалтай хорих ял шийтгүүлсэн хүмүүс тал хувь нь.

Тэгэхээр энэ хүмүүст эргээд гарахад нийгэмшүүлэх боломж олгох гэдэг үүднээс зарим улс орнууд ялгамжтайгаар хүнд гэмт хэрэг үйлдсэн, тодорхой зүйл, ангитай гэмт хэрэг үйлдсэнээс бусад хорих ял эдэлж байгаа хүмүүст сонгох эрхийг нь олгодог бас жишээ байна. Энийг бас олон улсын хорооноос зөвлөдөг юм байна. Иргэн ...тухайн улс өөрийнхөө үндэсний онцлогтой нийцүүлэн энэ эрхийг хязгаарлах эсэхийг бодож үзнэ үү гээд тэр утгаар нь эхний энэ хорих ял эдэлж байгаа хүмүүст сонгох эрхийг олгох боломжтой эсэхийг судлах талаар санал оруулсан.

Хоёр дахь асуултад Хүний эрхийн Үндэсний комиссын хэлтсийн дарга Ёндонжамц 5 номер дээр хариулна.

Ж.Бат-Эрдэнэ: 5 номерын микрофон.

Д.Ёндонжамц: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ёндонжамц байна. Улс, төрийн намуудад санхүүжилт олгох асуудлаар урьд нь Нээлттэй нийгэм форум болон Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс 2018 онд Монгол улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ байдаг. Энэ дүн шинжилгээний хүрээнд бас судлаад энэ улс төрийн Улсын Их Хуралд суудалгүй улс төрийн намуудад бас санхүүжилт олгох нь ийм ач холбогдолтой. Олон улсад бас ийм тогтсон жишиг байдаг. Энэний дагуу бас улс төрийн Улсын Их Хуралд суудалгүй намуудад санхүүжилт олгох нь цаашдаа тухайн намыг сонгуульд оролцуулахад дэмжлэг үзүүлэх нэг ийм хөшүүрэг болдог талаас нь судалгаанд дурдсан байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Зулпхар гишүүн тодруулна.

С.Зулпхар: Би сүүлийн хариулттай холбогдуулаад мэдээж хэрэг жишээ нь бид иргэдийн сонгох, сонгогдох эрхийг бүхий л түвшинд нээх нь ардчилсан дэглэм засаглалын чухал шалгуур л даа. Гэхдээ улс төрийн намуудыг бүхэлд нь хэрвээ ямар нэгэн байдлаар Их Хуралд суудлаасаа, суудалгүй байхаас нь үл шалтгаалаад санхүүжүүлнэ гэх юм бол яг өнөөдрийн манай улс төрийн нөхцөл байдал, соёл гэдэг юм уу эсвэл институтийн түвшин бол энд ...чадах уу гэдгийг бас та бүхэн бас бодох ёстой байх. Зөвлөмж өгсөн ч гэсэн. Та хэдийн зөвлөмжийг авчихдаг олон улсын байгууллагууд, гаднынхан ерөөсөө нэг л юм шахаад л байдаг юм шүү дээ. Тэгээд тэднийхний зөвлөсөн болгоныг бидэнд биелүүлнэ гэх юм бол манай нийгэмд энэ нийгмийн харилцааг зохицуулах ямар ч боломжгүй. Заримдаа бид бол хангалттай хэлж чаддаг байх ёстой.

Өөрийнхөө улс төрийн төлөвшил, улс төрийн тогтолцооны байгаа байдалд тохирсон байдлаар л бид зохицуулалт хийгээд явахгүй бол юм болгоныг л авч хийсээр байтал юу ч хийж чадахгүй ийм л байдал руу орчихдог учраас энэ дээр та бүхэн маань их сайн судалгаа хийж бас зөвлөмжөө гаргаж өгөөрэй.Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Хүний эрхийн комиссынхондоо баярлалаа. Ер нь эхний асуудал дээр Сонгуулийн тухай хууль тогтоомжтой холбоотой дүгнэлтүүдтэй бол санал нэг байна. Ялт ч байхгүй бид нар тэгш эрхийн зарчим, чөлөөтэй байх, сонгох, сонгогдох эрх дээр бол засварууд хийх ёстой гэдгийг харж байгаа. Мөн түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлттэй холбоотой мөн энэ дээр бас санал байна.

Харин хоёр дахь асуудлын хүрээнд буюу яг сэтгүүлчидтэй холбоотой, хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой асуудал дээр бол хэд хэдэн асуудал тодруулах зүйл байна. Миний хувьд бол яг Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль буюу бид нарын хамгийн боломжит хэмжээгээр ямар нэгэн хязгаарлалт оруулахгүйгээр цензурээс ангид байх, төрийн байгууллага оролцохгүй байх, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан ямарваа хууль батлахгүй байх гэдэг энэ агуулгаараа 98 онд баталсан хууль байгаа. Тэгэхээр энэ хуулийнхаа хүрээнд илүүтэйгээр детальчилж энэ хуулиа хөндөхгүйгээр харин бусад жишээлбэл зөвхөн яг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой, сэтгүүлчтэй холбоотой, тухайн редакцын чөлөөт байдалтай холбоотой, эсвэл эх сурвалжаа нууцлахтай холбоотой бусад хуулийн зохицуулалтуудаар хэрэгжүүлээд явах боломж байх уу буюу олон улсын энэ дээр яг олон улсын стандартад нийцсэн гэдэг байдлаар нэлээн их томъёолчихсон байна л даа.

Тэгэхээр яг энэ олон улсынхаа стандартаар энэ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль гэдэг нь энэ олон асуудлуудыг хоорондоо дотроо базсан ийм хууль байдаг юм уу? Жишээлбэл, Америк Улсынх бол ... нэгээрээ зохицуулаад явдаг гэж би ойлгож байгаа. Мөн түүнчлэн яг энэ асуудлууд дээр бид нар хүний эрхийн фактууд болон холбогдох олон улсын гэрээ, фактад бол нэгдэн орчихсон. Энийгээ хэрэгжүүлээд явах үүрэг нь байгаа гэж ойлгож байгаа. Мөн түүнчлэн Үндсэн хуулиараа бид нар энийгээ хүний эрх гэдгээр зөвхөн хэвлэл нийтлэхээс илүүтэй үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх ингээд багцаар нь бид нар эрх эрх чөлөөг баталгаажуулаад оруулчихсан.

Тийм учраас яг энэ хэвлэлийн эрх, эрх чөлөөний тухай гэж хуулиа явцууруулаад яг хэвлэл мэдээллийн байгууллагын тухай болгож өөрчлөх яг энэ асуудлууд руу хандаж орж ирэх нь өөрөө энэ яг цахим шилжилтийн гэдэг юм уу, өнөөгийн нийгэмд энэ нь өөрөө хэр зөв юм бэ гэдэг дээр эргэлзэж байгаа. Тэгэхээр энэ тал дээр олон улсын сайн туршлага юм нь ямар байна, тэр судалгааны хүрээнд яаж харсан бэ гэдгийг бас тодруулж асууя гэж хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерын микрофон.

С.Дондов: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэсэн энэ том үзэл бодлыг бол ялт ч үгүй хязгаарлахгүйгээр, үүнээс гадна бол хэвлэл мэдээллийн энэ эрх чөлөөнд бол ялт ч үгүй иргэдийн мэдэх эрх, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх сэтгүүлч иргэдийн байгаа нөхцөл байдлыг нийтийн мэдэх эрхийг хангах зорилгоор ажиллаж байгаа энэ явдлыг нь бол ямар нэгэн төрөөс хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжийг нь бүрдүүлсэн байх шаардлагатай гэж ингэж үздэг.

Мөн бусад дагаж гарсан хуулиудаар бол аливаа хязгаарлалтыг хийхгүй байх нь бол илүү зохимжтой гэж ингэж үздэг.

Гуравдугаарт бол ер нь мэдээллийн эх сурвалжийг хамгаалах, шинэ хэвлэл мэдээллийн платформыг орхигдуулахгүй байх өргөн агуулгаар хуульчлах явдал бол хамгийн чухал гэж ингэж олон улсын стандартад бол үздэг. Тийм учраас өмнөх бид нарын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль бол үнэхээр хэвлэлийн эрх чөлөөний өргөн агуулгыг бол багтааж чадсан. Тийм учраас үүнийг харин илүү хумихгүйгээр энийг илүү өөрийнхөө улс орны онцлог нөхцөл байдалд тохирсон ийм байдлаар хуульчлах явдал хамгийн чухал гэж ингэж үзэж байгаа.

Хоёрдугаарт бол хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай ажиллаж байгаа хэвлэлийн гол гол сэтгүүлчид өөрсдийнхөө нууц материал олж аваад тэрийгээ дэлгэснийхээ төлөө очоод хариуцлага хүлээгээд өндөр ял шийтгэл аваад явж байдаг, эсвэл асуудлыг нь шийдэх гэж байна гэдэг үндэслэлээр таслан сэргийлэх арга хэмжээний хамгийн хүнд хэлбэр болох цагдан хорих арга хэмжээ авч байгаа энэ явдал бол хэвлэлийн эрх чөлөөг бол маш бүдүүлгээр зөрчиж байгаа ийм үйлдэл. Хүний эрхийн хамгаалагчийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг бол сэтгүүлч байдаг.

Тийм учраас сэтгүүлчийг бол олон улсын хэмжээнд хүний эрхийн хамгаалагч гэж үздэг учраас тэр хүнийг аль болохоор үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах, нийтийн мэдэх эрхийг хангах, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй явуулах энэ боломжийг нь өргөн агуулгаар хуульчилсан ийм Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль байвал энэ олон улсын стандартад нийцнэ гэж үзэж байгаа.

Одоогийн байдлаар бол манай Монголд үндсэндээ үйлчилж байгаа 112 хуулиас бол үндсэндээ 112 хуулийн 67 нь бол хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан байдлаар хуульчилсан ийм хуулиуд байна гэж ингэж үзсэн. Мөн бусад телевизэд, 18 телевизэд бол давуу байдал олгосон ийм нөхцөл байдал бол бас судалгаагаар гарч байгаа. Тийм учраас аль болохоор сэтгүүлчийг үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь төрөөс хараат бусаар энэ үйл ажиллагаагаа явуулах боломжийг нь хангах шаардлагатай гэж ингэж үзэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Тэгэхээр яах вэ миний асуугаад байгаа юм болохоор яг ингээд Хэвлэлийн эрх чөлөөний тухай гээд хууль дотор энэ зохицуулалтууд нь бүгдээрээ орсон байдаг юм уу? Одоо яг тэр судалж үзсэн олон улсын гэрээнүүд, хуулиуд байна шүү дээ тээ? Тэгэхээр энэ дээр одоо яг би дан ялангуяа яг энэ манай бүлгийн гэдэг юм уу хууль тогтоомжийн системчлэл дээр энэ яаж системчлэгдсэн байдаг юм бэ? Энийгээ бүүр яг ингээд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль гэдэг дээрээ энэ сэтгүүлч, редакц, хариуцлагатай сэтгүүл зүй гэдэг юм уу энэ бүх ойлголтууд юмнууд нь ороод явчихсан байна уу яаж байна вэ гэдгийг яах вэ? Миний хувьд бол эмээгээд байгаа зүйл маань яг бид нар хэвлэлийн эрх чөлөө гэдэг юмаа баталгаажуулсан хууль маань өөрөө илүү байгууллагын шинжтэй болчих вий, тэгээд энийг хэр хэт нэг тал руу дөвийлгөчих вий. Дээрээс нь энэ дээр буцаад хариуцлагуудыг илүү тодруулж оруулж ирээд байгаа учраас санаа зовоод байгаа гэсэн үг.

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерын микрофон.

С.Дондов: Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль бие даасан байдлаар хараат бусаар тийм байгууллагын шинжтэй ийм зохицуулалт бол аль болохоор орохгүй байх ёстой. Тэнд сэтгүүлчид өөрсдөө үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх энэ боломжийг нь илүү олгосон. Ямар нэгэн байгууллагын тодорхой зүйл, заалтыг оруулсан, эсвэл сэтгүүлчийн үйл ажиллагааг хязгаарласан ийм тодорхой заалтууд аль болохоор оруулахгүй байх нь Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн гол агуулга болно.

Харин магадгүй хэвлэл мэдээллийн байгууллагын асуудлыг зохицуулсан редакцын хараат бусаар үйл ажиллагаа явуулах энэ бүх боломжийг нь юу зохицуулсан хуулиуд нь өшөө бусад хуулиараа зохицуулагдаж явдаг ийм үндсэн концепцтой гэж ингэж хэлж болно.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Маш чухал асуудлууд орж ирж байна. Тэгээд энэ ялангуяа сонгуультай холбоотой асуудал ерөөсөө энэ бүх болохгүй, бүтэхгүй байгаа зүйлүүдийн эх үүсвэр, эх сурвалж гэж би хувьдаа дүгнэдэг. Тэгээд одоо бид нар чинь сонгуулийн бус үеийн тэр шударга бус санал худалдаж авдаг ажлыг зогсоох нь бүү хэл хориглочихсон сонгуулийн үеийнхээ шударга бус явдалтай тэмцээд дийлэхгүй ийм байдалтай байдаг. Мянга мөнгө тараалаа гээд бүүр бариад, бөөн баримт бүрдүүлээд тагнуулд өгдөг, цагдаад өгдөг. Тэр ерөөсөө хэзээ ч тэр дээр хариуцлага тооцдог юм бүүр огт байдаггүй. Тэгэхээр энэ та бүгдийн энийг уншихаар мэдээж сонгууль бол чөлөөтэй байх зарчим, саналаа нууцаар гаргах зарчим хэд хэдэн зарчим байгаа. Энэнээс ердөө хамгийн чухал 2 зарчим сонгууль фэйр энд фрий/fair and free/ гээд чөлөөтэй бөгөөд шударга байх ёстой гэдэг ийм 2 зарчим хамгийн чухал зарчим.

Тэгэхээр чөлөөтэй байх дээр та бүхэн энд дүгнэлт өгсөн байна. Тэгэхээр сонгуулийн хамгийн чухал буюу шударга байх ёстой гэдэг энэ зарчмын талаар хэрэгжилтийнх нь талаар та бүхэн юу гэж үзэж байгаа юм болоо? Энэ дээр ер нь тусгагдсан юмыг би харахгүй байна. Нэгд.

Хоёрт, энэ хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилтийн талаар энэ индексүүд байх шиг байна тээ? Тэгэхээр энэ дээр руль оф лоо /rule of law/буюу эрх зүйт хуулийн засаглалын индекс ийм 24 онд 142 орноос 66 дугаар байранд байна гэсэн байна. Иргэний шүүхийн шударга байдлын үнэлгээгээр мөн 65-д байна гэсэн байна. Тэгэхээр энэ 24 оны байдал өмнөх 10 жилийн интервалтайгаар авч үзэж байж бид нар дээшилж байна уу, доошилж байна уу гэдгийг нь харна шүү дээ. Тэгэхээр энийг өмнөх үеүдэд ер нь ямар байж байна вэ? Манай хуулийн засаглал маань хэр зөв тийшээ, эсвэл буруу тийшээ явж байгаагийн илрэл. Энэний өмнөх онуудын энэ индексийг та бүхэн мэдэж байгаа хэлж өгөөч гэж.

Гурав дахь асуулт хэвлэлийн эрх чөлөө. 4 дэх засаглал гэж хэлдэг тээ? Тэгээд төр, хэвлэл хоёр хэзээ ч хутгалдаж зууралдаж болохгүй. Энэ бүр зарчмын хувьд бүр бүр маш хориотой зүйл байх ёстой атал сүүлд орж ирсэн хуулийг та бүхэн сонирхсон уу? Тэн дээр маш ноцтой заалтууд орж ирж байна лээ. Бүр улам ухарсан. Жишээлбэл бүр тендер зарлаж байгаад сонгон шалгаруулалт хийж төрийнхөө албыг сурталчлуулна ч гэж орж ирсэн байх шиг, төлбөр төлсөн агуулгыг нь би яг точный санахгүй байна. Гэхдээ төлбөр авсан тэр эх сурвалжийг нийтэд мэдээлнэ гэж байгаа байхгүй юу. Тэр чинь юуг хэлж байна гэвэл сэтгүүл зүйн тэр эх сурвалжаа нууцлах гэдэг зарчмыг бүхэлд нь үгүйсгэсэн ийм маш ноцтой

заалтууд орж ирсэн гэж би харсан. Тэгэхээр энэ дээр бас та бүгдийн санаа бодол юу байна вэ?

Энэ 13.14-ийг би бас танай байгууллагад их талархдаг. Ямагт энэ бол буруу Эрүүгийн хуулиас авч хаяна уу? Худал мэдээлэл тараах, гүтгэх.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон.

Д.Сүнжид: Баярмаа гишүүний эхний асуултад хариулъя. Шударга байх зарчим үндсэн тулгуур зарчим. Тэгэхээр яг нарийвчилсан 4 зарчмыг нь нарийвчилж тайлбарласан. Тэгээд нийлээд сонгуулийн зардлын хэмжээ, ердийн дундаж иргэн өрсөлдөх боломж өгч байгаа эсэх, тэгээд нам эвслүүдийн мөрийн хөтөлбөр, сонгуулийн сурталчилгаа, мэдээллийн ил тод байдал, сонгогчдын боловсрол, тэгээд энэ 4 нарийвчилсан зарчим, гомдол маргаан хянан шийдвэрлэж байгаа байдал бүгдээрээ нийлээд л сонгууль өөрөө процессын хувьд материаллаг хувьд аль аль нь шударга явах ёстой.

Тэгээд таны хэлж байгаатай санал нэг байна. Энэ өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж байгаа байдал дээр хамгийн анх би танилцуулгаа хэлэхдээ дурдсан 4 судалгаа бид нар хийлгэсэн. Тэр 4 судалгаан дээр гарч ирж байгаа дүгнэлт нь яг энэ дахин сонгууль болгоноор давтагддаг үзэгдлүүд байна. Мөнгө тарааж байна гэж байна, өрсөлдөгчийнхөө материал, ухуулах материалд нь гэмтээдэг гэж байна, ухуулагчийг бас худалдаж авахыг олдог гэж байна гээд ийм давтагддаг давтагддаг шинээр гарч ирээгүй ийм зөрчлүүдийн асуудал яригдаад байгаа боловч энийг хэрхэн шийдвэрлэсэн юм үр дүнтэй шийдвэрлэсэн юм уу, хариуцлага тооцсон юм уу гэдэг мэдээлэл олон нийтэд өгдөг ч үгүй юм байна. Цөөхөн хувь нь шийдвэрлэгддэг ч юм байна гэхээр ер нь хариуцлагын тогтолцоо, хяналтын тогтолцоо муу ажилладаг юм байна гэдгийг нь дүгнэсэн.

Тэгэхээр одоо бид нарын хэлээд байгаа санал нь нэгэнт бид нар мэдэж байгаа юм бол ялангуяа тэр зардалтай холбоотой, хандивтай холбоотой асуудал, тэр юутай холбоотой асуудал Үндэсний аудитын газар өгдөг мэдээллийн тайлангийн асуудал байна. Нэмэх нь саяын хэлдэг тэр их нийтлэг гараад байгаа Цагдаагийн байгууллагадаа өгөөд байгаа энэ өргөдөл, гомдол, мэдээллийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэдэг механизм бүрдүүлэхгүй бол яг өгдөг боловч эцэст нь тэгээд яасан юм сонгуульд яаж нөлөөлөв өө гэхээр бид нар тийм энийг бид нар хянан шийдвэрлээд дуусгалаа, мэдээллээ өглөө гэж ингэж хэлж мэдээлж чадахгүй байдалтай байгаа. Тэгээд энд нь хууль бас нөлөөлж байна. Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиас жишээ авсан тэр дээр сонгуулийн үеэр хууль бус үйл ажиллагаа явуулах юм бол гээд тэр санкц нь маш харилцан адилгүй ялгаатай тогтоочихсон.

Хэрвээ 10, 11 сая төгрөгийн билүү уучлаарай 100 мянган төгрөг юм байна. Жишээ авчихсан, 100 мянган төгрөгийн хандиваа бүртгүүлээгүй гээд. Тэгээд тэр санкц нь болохоор 10 сая төгрөгөөр торгоно гээд. Ингээд маш ийм хэлбэлзэлтэй байгаа. Тэгээд 2 дахь энэ дээр нарийвчилсан судалгаан дээр дурдсан асуудал юу вэ гэхээр иргэд, нэр дэвшигчид, намынхан бас ингээд гомдлыг тухайн сонгуулийн үеэр гаргаад үр дүнтэй хянан шийдвэрлэнэ гэдэг итгэл бас буурсан байна гэж түүнээс өмнөх сонгуультай харьцуулах юм бол.

Тэгэхээр энэ механизм өөрөө бүхэлдээ циклээрээ үр дүнтэй ажиллаж байна уу, үгүй юү тэр хууль тогтоомжийн хувьд, хэрэгжилтийн хувьд дүгнэх

шаардлагатай, сайжруулах хэрэгтэй гэж байгаа юм. Санал нь. Дондов гишүүн хариулах уу?

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерын микрофон.

С.Дондов: Гишүүний асуултад хариулъя. Тэгээд Сивил жастис олон улсын байгууллагаас бол үндсэндээ яг Монгол Улсын шударга ёсны байдал, шүүхээр эцэслэн шийдэгдэж байгаа хэргүүдэд анализ хийж үнэлж үзээд үндсэндээ 23 оны байдлаар бол үндсэндээ манайх яг одоогийн байгаа юунаасаа үл ялиг бага байсан. 22 онд бол эрүүдэн шүүхийн эсрэг бие даасан ийм механизмтай болсон явдал нь бол энэ Сивил жастисын үнэлгээгээр тодорхой хэмжээнд үл ялиг 0.5 хувиар нэмэгдэх ийм боломжийг бол олгосон.

Ер нь бол энэ шударга ёсны төлөөх энэ төслийн гаргаж байгаа юуг харьцуулаад 23, 22-25 онд ингээд яахад ер нь тогтвортой ингээд л байдаг. Тэгээд үл ялих жоохон дээшилсэн юм нь үндсэндээ тэр эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх бие даасан механизмтай болсон явдлаас л үл ялыг дээшилсэн. Түүнээс биш яг энэ бүхэлдээ илүү сайжраад байна гэж үзэх ийм юу хангалттай биш байна гэж ингэж үзэж байгаа. .../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерын микрофоныг.

С.Дондов: Шинээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулан гаргасан. Ингэхдээ энд олон нийтийн саналыг нийтийн мэдэх эрхийг хангаж олон нийт өөрсдийнхөө мэдэх эрхийг хэрэгжүүлэх, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактад заасан ямар ч хэлбэрээр улс орны хаана ч, улс орон дамжаад ч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх энэ боломжийг Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд илүү тодорхой тодорхой зааж өгөх ёстой.

Харин одоогийн оруулж ирсэн зохицуулалтаар бол байгууллагуудын жишээлбэл зарим тохиолдолд сэтгүүлчийн хариуцлагын асуудлыг илүү түлхүү оруулж ирж байгаа. Зарим тохиолдолд дундаас нь сонгон шалгаруулалт хийх, тендер зарлах гэх мэтийн ийм сэтгүүлчдэд халтай байж болох байсан ийм заалтууд орсон явдал нь бол хэвлэлийн эрх чөлөөний гол үндсэн үнэт зүйл болох хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахад бас тодорхой хэмжээгээр мөн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Шударга явагдахгүй байгаа нь илэрхий атал хариуцлага тооцох механизм ажиллахгүй байна гэдэг дээр та бүгдэд ямар санал байгаа юм бэ? Энэ санкцыг нь хүндрүүлэх ёстой юм уу? Олон улсын туршлага юу байдаг юм бол? Яагаад энэ 1 ч хүнд хариуцлага тооцогдохгүй, тэгээд 1 ч Улсын Их Хурлын гишүүн эргэж татагдахгүй тэгээд л ингээд л цаашаа үргэлжлээд л амьдрал юу ч болоогүй мэт ингэж үргэлжилсээр байгаад өнөөдрийг хүрлээ шүү дээ. Тэгээд нэг нь хариуцлага тооцдоггүй юм чинь тэр жишээ нь зүгээр мөнгө тараадаг хүмүүс болихгүй шүү дээ. Тэгэхээр олон улсын туршлага юу байдаг юм? Энийг бид нарыа зогсоох ёстой юм болоо? Санкцыг нь өндөрсгөх юм уу, эсвэл энэ дээр ту судалсан юм байвал хэлээч. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон.

Д.Сүнжид: Ерөөсөө олон улсын туршлага бол цаг хугацаа. Яаралтай нэн даруй хурдан шийддэг юм байна. Нэхэмжлэл гаргах, үнэхээр их хэмжээний нотлох баримт цуглуулах, шинжээч энэ тэр холбогдох биш л яг яриад байгаа энэ зөрчлийн шинжтэй үйлдлүүдийг даруй шийддэг хугацааны асуудал байна.

Хоёрт нь хэрхэн шийдвэрлэв гэдгээ зөвхөн тухайн холбогдогч этгээдэд биш нийтэд мэдээлдэг туршлага байна. Тэдэн гомдол ирлээ. Жишээлэх юм бол мөнгө тараасан гэх гомдлыг бид нар ийм ийм үндэслэл дээр хэрэгсэхгүй болгосон. Тэдийг нь бид нар ингээд шийдээд хариуцлага хүлээлгэчихсэн юм. Тэгэхээр хариуцлагын хэмжээ, санкцын асуудал 3-д нь яригдаж байгаа юм. Тэгээд манай дээр дүгнээд байгаа нь санкц гэхээсээ илүү эхний 2 хугацаа, нийтэд мэдээлэх байдал өөрөө дутагдалтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Хүний эрхийн эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг ч бас олон удаа л ярьж байна даа. Төрийн байгуулалтын байнгын хороо руу орж ирж байгаа 2 сэдэв байна. Сэтгүүлчийн эрх чөлөөний асуудал. Нэг нь сонгуулийн шударга байгаа, сонгуулийн тогтолцооны асуудал ямар байна вэ гэж. Та бүхний сонгуультай холбоотой гаргасан дүгнэлтэд 8 санал байгаад байх юм. Мандатын тоонд ноогдох тойргийн сонгогчдын тооны хэт зөрүүтэй байдлыг арилгах гэж. Энэ саналыг яагаад гаргах болсон юм бэ?

Тухайлбал, би ингээд сая 24 оны сонгууль томсгосон тойргоор боллоо. 13 тойрогт хуваагдаж явагдсан. Бүсчилж тойргуудыг хуваасан. Зарим ай тойрог 4 аймгаас бүрдэж байгаа, 10 мандаттай гэх мэтчилэн ингээд. Ингээд харахаар сонгогчдын тоонд хуваахаар жишээ нь 1 дүгээр тойрог ч юм уу 4 аймгаас бүрдэж байгаа 1 дүгээр тойрог, 191 мянган сонгогчтой. Тэгээд 10 мандаттай. 191-ийг 10-д хуваахаар 1 нэр дэвшигчид 19 мянган хүн л оногдож байна шүү дээ тийм үү? Гэтэл хамгийн бага хүн амтай тойрог гэдэг юм уу манай тойрог 13 дугаар тойрог, Багануур, Багахангай, Налайх 2 мандаттай, 50 мянган сонгогчтой. Хуваахаар 24, 25 мянган 1 нэр дэвшигчид ноогдож байгаа сонгогчийн тоо. Ингээд тооцохоор ингээд аймгуудыг ингээд тооцохоор янз бүр. Дунджаар 19, 20 мянга л юм байна шүү дээ. Энэ олон мандаттай аймгуудаас гарч ирж байгаа.

Харин Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг ялгаатай байна. СХД, БЗД хамгийн олон нэр дэвшигчид 54 мянган сонгогч нэр дэвшигчид оногдож байна. СХД-т 35 мянган сонгогч оногдож байна. Тэгэхээр энийг цаашдаа яадаг юм олон улсад дунджаар энэ 1 нэр дэвшигчид оногдох сонгогчдын тооны зөрүү дунджаар 15 байх ёстой юм уу? Гэхдээ бид нар чинь энэ сонгуулийн тойргийн мандатыг хуваарилалтыг хийхдээ бас газар нутгийн байршлыг харгалзаж байгаа шүү дээ. Хүн амын тооноос гадна газар нутаг, нутаг дэвсгэрийн зарчмыг хангаж байгаа. Бас тухайн газар нутгийн хүн ам багатай гээд төлөөлөл цөөтэй байх ёстой гэж ингэж тухайн тойрог, тухайн хилийн цэс, нутаг дэвсгэр Их Хуралд өөрийн гэсэн төлөөлөлтэй байх ёстой гэж үзэж байх зарчим бас талаас хангаж байх ёстой шүү дээ. Энэ дээр та нар хариулт хэлээдэх.

Ж.Бат-Эрдэнэ: 6 номер. Дараа нь тодруулъя.

Ч.Ариунаа: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө.

Ж.Бат-Эрдэнэ: Өөрийгөө танилцуулаарай.

Ч.Ариунаа: Хүний эрхийн Үндэсний комиссын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ахлах референт Ариунаа байна. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд яг тойргоо байгуулах талаар хуульчилсан, тойрог хуульчлахдаа энэ тогтоол гаргахаар хуульчилсан байгаа. 2024 оны сонгуулиар болохлоор энэ тойрогт хуваасан сонгогчдын тоо нь хэтэрхий хэт зөрүүтэй байна. Олон улсад болохлоор Копенхагены зарчим гэж байдаг. Энэ зарчим дээр болохлоор сонгогчдын тоо нь 15 хувиас, 10-15 хувиас хэтрэхгүй ийм хэлбэлзэлтэй байхаар тогтоосон байдаг. Манай улсын хувьд болохлоор хэт зөрүүтэй байна гэж үзсэн байгаа. 50 хувиар, Улаанбаатар хотын 4 тойрогт 50 хувиар хэтэрсэн нь тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байна гэж үзэж байгаа.

Жишээлбэл, 1 тойрогт тухайлбал 12 дугаар тойрогт 3 мандаттай байхад 57545, хамгийн бага буюу 2 дугаар тойрог 10 мандаттай 19652 сонгогчтой байна гэж үзсэн. Тэгэхээр 1 тойрогт хэтэрхий олон мандат байхад зарим тойрогт цөөхөн мандаттай хэр нь хэт хэтэрсэн их сонгогчтой байхаар ийм тойргоо зохион байгуулалтад оруулсан байгаа. Тэгээд яг энэ тойргийнхоо хуульчилсан нь болохлоор газар зүйн тэр нутаг дэвсгэрийн зохион байгуулалт болон тухайн нутаг дэвсгэрийн сонгогчдын тоо, хүн амын тоог харгалзан үзнэ гэж хуульчилсан хэдий ч болохлоор яг бид нарын өгч байгаа санал болохлоор яг энэ тоог болохлоор үндэслэж, тойргийнхоо мандат, тойргоо хуульчилсан нь зүйтэй гэж үзээд байгаа юм. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн тодруулна.

Ц.Сандаг-Очир: Сонгуулийн хууль 8 удаа явагдсан. Жил ирэх тусам сонгуулийн хуулийн бид бүхэн алдаа оноог засаж залруулах гэж л хийгээд л байгаа. Дөнгөж саяхан жишээ нь Үндсэн хуулийн цэцийн 3 дугаар дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулаад тэгш эрхийн зарчмыг хангаж, сонгуульд нэр дэвш, Улсын Их Хурлын гишүүд, сайд нар сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэлх хугацаанд хэвлэмэл материал тарааж болохгүй гэдгийг хуульчилчихсан Цэцийн дүгнэлтийг хүлээж аваад. Энэ бас нөгөө талаараа тэгш эрхийн зарчмыг хангаж байгаа нэг Улсын Их Хурал нийцүүлж байна шүү дээ.

Тийм учраас ингээд өнгөрсөн хугацаанд хэн нэгэн давуу байдлыг бий болгохгүйгээр албан тушаалтнуудад бүгдээрээ сонгуульд нэр дэвшигч нар адилхан тэгш гараанаас эхэлье гэдэг энэ зарчмаар ингээд энийг хуульчилсан байх жишээтэй. Уулзалт, тайлан хурлаа хийх нь, иргэдтэй хийх уулзалт нь хэн бүхэнд нээлттэй ийм байдлаар ингээд цаашдаа сайжруулаад явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Сэтгүүлчтэй холбоотой асуудал, сэтгүүлчийн эрх эрх чөлөөтэй холбоотой. Өнөөдөр энэ улс төрийн намууд болохоор санхүүжилт нь хаанаас бүрдэж байна вэ гэж. Ингээд төсвөөс бүрдэх нь нэг хэсэг нь, тэгээд намынхаа гишүүн сонгуультнуудынхаа хандив, тусламжаар ингээд явж байгаа хураамжаар. Тэгтэл сэтгүүл зүйн байгууллагууд хаанаас санхүүжилтээ бүрдүүлж байгаа вэ гэж. Түрүүн тэр Дондов гуай хэлсэн улс төрөөс хараат байна гэж сэтгүүлчид, сэтгүүл зүйн байгууллагууд. Үгүй ийм байхаас өөр аргагүй. Өнөөдөр сэтгүүл зүйн байгууллага чинь өөрөө ямар төсвөөс цалин мөнгө, урамшуулал авахгүй байгаа учраас өөр хаанаас цалинжиж явах юм, урамшуулал авах юм?

Тэгэхээр ер нь цаашдаа энэ хараат байдлыг ингээд ийм байгаа байдал байгаа учраас улс төрийн намаас, төрийн байгууллагуудаас, улс төрчдөөс хараат байгаад байна гээд байна шүү дээ. Тэгээд хараат байлгахгүйн тулд яах ёстой юм тэгвэл? Төсвөөс урамшуулал, цалин өгөх ёстой юм уу, яах ёстой юм хараат байлгахгүйн тулд? Тэдний чинь оршин тогтнох үйл ажиллагаа явуулах нь улс төрийн намуудтай гэрээ хийж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон. 3 уу? 3 номер.

С.Дондов: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ер нь яг өнөөдрийн манай нөхцөлд сэтгүүлчдийн ажиллаж байгаа сэтгүүлчдийн өөрсдөө хэлж байгаа асуудал бол бид нарт үнэхээр эдийн засгийн хувьд бол бид нар баталгаатай биш байна. Тийм учраас бид нар бол улс төрийн албан тушаалтнуудтай гэрээ байгуулах, тэр дээрээ үндэслээд үндэслэлтэй, үндэслэлгүй тийм мэдээ, мэдээллүүдийг гаргах ийм төвөгтэй байдлууд гарч байна гэдэг дээр бол хүлээн зөвшөөрч байгаа.

Хоёрдугаарт бол үндсэндээ хуулийн этгээдийн хэлбэртэй үйл ажиллагаа явуулж байгаа, редакцын хараат бус үйл ажиллагаа явуулах энэ боломжийг хангаж өгөөч гэж хэлж байгаа.

Жишээлбэл, редакцын хараат бус байдал гэдэг нь юу вэ гээд тэгэхээр зэрэг ялт ч үгүй хуулийн этгээд болсон энэ байгууллага дээр сэтгүүлчээр ажиллаж байгаа тохиолдолд тодорхой хэмжээний цалин авдаг. Гэхдээ тэр цалин нь бол өнөөгийн нөхцөлд бид нар амьжиргааг юу яах ямар ч боломж байхгүй байна. Тийм учраас бид үйл ажиллагаагаа хэн нэгний хараат бусаар үйл ажиллагаа явуулахад төвөгтэй байна гэсэн ийм асуудлыг ярьж байгаа. Тийм учраас ялт ч үгүй.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон нэмж тодруулъя.

Д.Сүнжид: Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой хүний Хүний эрхийн Үндэсний Комиссоос Нарантуяа гишүүн Иргэний болон олон улс төрийн эрхийг хариуцдаг. Тэгээд хуулийн ажлын хэсэгт нь ажиллаж байгаа. 4 зарчим л бид нар ярьж байгаа. Санхүүгийн хувьд яаж хараат бус байх вэ гэвэл төлбөрөө ав, тэгэхдээ төлбөртэй гэдэг, гээд шошго юугаа тавьчих. Энэ бол төлбөртэй мэдээлэл юм гэдгээ тавиач гэдэг ийм л асуудлыг тавьж байна.

Тэрнээс яг төсвөөс санхүүжнэ гэх юм бол тооцоолж бодож үзсэн л дээ. Олон удаагийн бид нар хэлэлцүүлэг хийсэн. Олон удаа тэр сэтгүүлчидтэй, иргэний нийгмийн байгууллагуудтай, олон талтай ингээд хэлэлцүүлэг хийгээд явчихад тэр төсвөөс санхүүжнэ гэдэг одоохондоо тийм боломжгүй тийм шийдэл бас ингэж зөвхөн төсвөөс санхүүждэг тийм туршлага ч бас алга байна. Тэгэхээр бид нар санхүүжилтийн хувьд яах вэ гэхээр төлбөрөө авсан юм бол төлбөртэй гээд гэдэг тэр юугаа тавиач гээд буланд нь тэрийгээ тавиач гэдэг асуудал.

Төрийн байгууллагууд ингээд сэтгүүл зүйн нэгжтэй болж байна гээд байгаа. Болно тэгэхдээ тэн дээр бас тодорхой хязгаарлалт хийхгүй бол сүүлдээ нээлттэй мэдээлэх гэдэг процесс чинь өөрөө алга болох ийм шинжтэй юм байна. Тэгэхээр тэр.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Өмнөх гишүүдийн асуусан асуулттай давхцуулахгүй байхыг хичээ. Нэгдүгээрт нь 2 хэсэг салгаж асуултууд асуух гээд байгаа юм Нэгдүгээрт нь ерөнхий энэ илтгэлийн тухайд 6 бүлэг байгаа нь миний хувьд ингээд харахад жоохон учир дутагдалтай юм уу гэж харагдаад байна. Арай тийм харьяалуулсан шинж чанартай, арай жоохон өргөн байж болохгүй юм уу гэдэг зүйлийг нэгдүгээрт нь ярих гээд байгаа юм.

Энэ нь ямар учиртай юм гэхлээр зарим улсад эрх чөлөөний тухай гэдэг юм уу, Иргэний эрхийн тухай хууль ч гэдэг юм уу ингээд хуулиуд байж байдаг. Улсын Их Хурлын даргад Их Хурлын гишүүний хувьд санал өгөөд эрх чөлөөний тухай хуулийн ажлын хэсэг байгуулъя гээд санал өгчихсөн байгаа. Тэр маань ажлын хэсэг байгуулагдчих юм шиг байна гэж ойлгосон. Тэгэхээр бид нар өөрсдийн эрх чөлөөний тухай хуультай бол яасан юм? Жишээ нь хэвлэл мэдээлэл юм уу тээ, тэгээд тус тусад нь салгадаг биш. Ингээд хүмүүсийн эрх чөлөөг хангаж байгаа зүйлүүдийг бид нар энд тэндээс олж хараад байгаа шүү дээ. Эрүүгийн хуулиас зарим хэсгийг нь, бусад хуулиудаас, Байгууллагын тухай хуулиудаас бараг маш багыг.

Тэгэхээр яг Үндсэн хуулийн хүний эрхийн бүлэгтэйгээ холбогдуулаад Эрх чөлөөний тухай хууль гэдэг юм уу, Иргэний эрхийн тухай хууль батлагдаад Улсын Их Хурал хууль тогтоохдоо тэр хуульд нийцүүлж энэ байгууллагын хуулиуд байдаг юм уу энэ янз бүрийн төрийн байгууллагын хуулиуд ордог. Энэ чиглэлээр ажиллах тийм боломж байдаггүй. Энэ дээр ажлын хэсэг байгуулагдвал та бүхэн бас ажлын хэсэгт, багтаж ороод ажиллах боломжтой юу, үгүй юү? Энэ талын ойлголт нь хэр байдаг юм? Хүний эрхийн Үндэсний комиссыг уг нь хамгийн их хүний эрхийн мэдрэмжтэй хүмүүс байх ёстой гэдэг зарим зүйл дээр ярьж байгаа зүйл хэвлэлийн хурал бусад энэ танилцуулга, хэлэлцүүлэг янз бүрийн зүйл дээр заримдаа харахад хэцүү санагддаг юм шүү дээ.

Нэг талдаа ингээд хүний эрхийг хамгийн их зөрчигч буюу хуулиар зөрчиж болдог, бас хууль бусаар одоо хуульгүй байсан ч зөрчих тэр хандлага давамгайлсан газар гэвэл ерөөсөө л Засгийн газар буюу эрх мэдэлтэй байгууллагууд шүү дээ. Хувь хүмүүс бие биеийнхээ эрхийг зөрчих Эрүүгийн хуулиар хаагдаад явчихдаг, тэнд эрхүүд нь хамгаалагдаж байдаг. Үүнтэй холбоотойгоор Эрхийн эрхийн тухай асуухаар хэвлэл мэдээлэл, олон нийт, эвлэлдэн нэгдэх эд нар гээд л улс төрийн нам байгуулахад хүртэл Дээд шүүхийн тэр бүртгэлийн журам дээр хүртэл эрхүүдийг нь зөрчөөд л байгаа шүү дээ. Нөгөөдүүл нь янз бүрийн юм хэлээд байдаг. Та нар энэ тухай дуугарсан, анхаарсан юм байдаг юм уу, байдаггүй юм уу? Эрх, эрх чөлөө бас нөгөө талдаа санхүүгийн эрх чөлөөтэй буюу өмчийн эрх чөлөөтэй зайлшгүй холбоотой. Маш олон хүмүүс бид нарын санхүүгийн эрх чөлөө рүү хал.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? 4 номер.

Д.Сүнжид: Батбаатар гишүүний 2 ерөнхий асуулт, 1 нь санал юм байна. Тэгээд 6 бүлэг яаж сонгодог вэ гэвэл Хүний эрхийн Үндэсний комисс 2020 онд стратегийг баталсан. Тэр стратегийн хүрээнд өнгөрсөн хугацаанд тулгамдсан буй асуудал байгаа юм. Тэгээд анхаарал төдийлөн хандуулахгүй буюу Хүний эрхийн Үндэсний комиссоос ялангуяа тодорхой бүлгийн, зорилтот бүлгийн, 13 бүлгийн эрхийг хэрхэн хангаж байгаа вэ гэдэг дээр ямар байдлаар анхаарал хандуулж энэ

тогтолцооны хувьд асуудлыг шийдвэрлэхийн төлөө чармайх ёстой гэдэг стратегид авч үзсэн. Энийгээ баримталдаг.

Гурав дахь нь шинээр үүсэж байгаа хүний эрхийн асуудлууд байвал тэрийг нь бас тухайн жилдээ бид нар авч үзэж дүгнэх ёстой гэдэг ийм үндсэн шалгууруудаар бид нар авч үздэг юм. Бүлгийн хувьд ер нь олон юм уу, эсвэл цөөн байх боломжтой.

Эрх чөлөөний тухай хуулийн тухайд ажлын хэсэг байгуулагдвал бид нар ороод ажиллахад бэлэн.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн нэмж асуулт асууя.

Б.Батбаатар: Баярлалаа. Тэгээд энэ парламентын засаглалтай улс оронд чинь сонгох, сонгогдох эрх гэж байгаа. Сонгох эрхийг нь зөвхөн яриад сонгогдох эрхийг нь хаачихвал угаасаа сонгох эрх нь дагаад хамт алга болчихно. Нэр дэвшсэн хүмүүс миний ойлгосноор Ерөнхий аудиторын баталсан журмаар 6 сарын 8-нд гэсэн байх. Баталсан журмаар хөдөлмөрийн хөлс юуг 100 дахин үржүүлээд торгууль, шүүх эд нар дээр яваад байгаа. Хуульдаа болохоор 2-хон зүйл, заалттай байсныг журмаар хандивын хэмжээг 5, 6, 7, 8 мэдүүлэг бөглөж байж хийдэг болгочихлоо гээд иймэрхүү зүйлүүд яваад байгаа. Тэгэхээр нэр дэвшээд сонгогдоогүй ч гэлээ тэр хүмүүсийн нэр дэвшсэнийхээ төлөө торгуулаад байгаа эрх чөлөө, эрх чөлөө нь хөндөгдөөд байна уу, үгүй юү гэдэг энэ талууд дээр ажиллаж байгаа зүйлүүд байна уу? Өнөөдөр ингээд хууль тогтоогч болон.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт өгье. 4 номер микрофон.

Д.Сүнжид: Батбаатар гишүүн сүүлийн 2 асуултад нь хариулъя. Торгууль нэр дэвшигчийн талаас 2 асуудлыг л ярьж байгаа юм. Нэгдүгээрт тэр сонгуулийн сурталчилгааны хугацаатай холбоотой асуудал, сонгуулийн зардлын асуудал, тэгээд тайлагналтай холбоотой асуудал, яг таны хэлсэн асуудлыг бид нар кэйсээр болон тоо баримтаар нь оруулсан. Энэ одоо ч дуусаагүй үргэлжилж байгаа. Татварын ерөнхий газар, Сангийн яаман дээр асуудлууд нь үргэлжлээд явж байгаа, дуусаагүй юм байна лээ. Тэгэхээр энэнтэй холбоотой яг журмаар ингэж хуульд заагаагүй асуудлыг журмаар зохицуулах нь өөрөө эрх зүйн эрэмбийн хувьд зөрчилтэй гэдгийг нь дүгнэсэн. Тэгээд энийг залруулах шаардлагатай гэдгийг нь тусгасан байгаа.

Хоёр дахь асуудал хүний эрхийн чиглэлээр хууль тогтоомжид санал өгсөн үү гэж. Өгсөн жилд бид нар 160, хэрвээ зүйл, заалтаар нь салгах юм бол 160 зүйл, заалтаас санал өгдөг. Хууль тогтоомжийн тоогоор нь ярих юм бол бид нар дор хаяж 20 хуульд санал өгдөг. Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгчөөс гадна бид нар өөрсдөө энэ нь өөрөө хүний эрхийн асуудлыг зохицуулж байгаа гол, цөм оролцох ёстой гэж үзсэн асуудал дээрээ бид нар бас өөрсдийн санаачилгаар бас санал.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд ас асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. Санал хэлэх гишүүд байна уу?

Зулпхар гишүүнээр тасаллаа.

С.Зулпхар: Баярлалаа. Энэ Хүний эрхийн Үндэсний комисс бол жил болгон холбогдох чиглэлээр өөрийнхөө чиг үүргийг бол хэрэгжүүлэхэд их тэвчээр гаргуулж ажиллаж байгааг бид мэдэж байгаа. Бас нэг талаар сайшааж байгаа. Яг гаргасан зөвлөмжийн авч байгаа, авахгүй байгаа асуудал байгаа байх. Тэр бас харьцангуй л зүйл л дээ. Зарим нь авна, зарим нь авагдахгүй ийм байгаа байх.

Гэхдээ бол нэгэнтээ Хүний эрхийн комиссоос хүний эрхийн жишээ нь зөрчил гэдгийг юм уу, хүний эрхийг илүү жишээ нь дээрдүүлэхтэй холбоотой зөвлөмж өгч байгаа бол авч ажил хэрэг болгох, хууль болон бусад холбогдох журамд нийцүүлэх, цаашлаад энэтэй холбоотой зөрчлийг арилгах чиглэлээр санаачилгатай ажиллах, идэвхтэй ажиллах, чиг үүргийг хэрэгжүүлэх нь төрийн байгууллага болон бусад субъектүүдийн бүгдийнх нь үүрэг. Энэ талаас нь бас бодох ёстой байх.

Би энэ хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой зүйл дээр нэг зүйл сая бидний яриагүйтэй холбоотой зориуд ярьж бодож байна. Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөний асуудал дан ганц хэвлэл мэдээллийн байгууллагуудын эрх чөлөөний асуудал биш, иргэдийн мэдээлэл авах эрхтэй шууд холбоотой ийм зүйл юм. Тэгэхлээр та бүхэнд би зориуд мэдээлэл болгоё энэ дээр та бүхэн ажиллах байх гэж бодож байгаа юм. Үүнээс 60 жилийн өмнө Монгол Улсад үндэсний цөөнх эх хэл дээрээ авах радио байгуулагдсан байдаг юм. Энэ радио Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулж байна л даа. Тухайн үед бид чинь нийгмээ бол юу гэж хэлдэг байсан гэхлээр зэрэг жишээ нь манай нийгэм бол жишээ нь хүн болгон тэгш эрхтэй байх ийм нийгэм байгуулж байна гэж үзсэн үүднээс иргэддээ эх хэл дээрээ мэдээлэл авах, эх хэл дээрээ мэдээллийг түгээх ийм боломжийг олгосон. Энэ бол үргэлжлээд явж байгаа. Сайн хэрэг гэсэн үг.

Гэхдээ бид чинь өнөөдөр бол тухайн үеийн нийгмийг бол авторитар ийм дэглэмтэй нийгэм ч бас хүний эрхийг хязгаардаг нийгэм гэж ярьдаг юм шүү дээ. Гэтэл тэр үед бид нар хүний эрхийг ингэж хангасан байна гэж байгаа юм. Монгол Улсын бас давуу тал. Өнөөдөр энэ үргэлжилж байна. Гэхдээ бас жоохон асуудал байна. Та бүхэн бас энийг заавал судлаад оруулаарай. Над дээр бас саналууд ирсэн. Би Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль дээр бас санал оруулах гээд бэлдэж байгаа юм. 3 хуулийн хоорондын зөрчлөөс болоод тэр радио үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй байдал үүсчихсэн байгаа юм. Тэгэхээр зэрэг энийг бол гаргах чиглэлээр энэ зөрчлийг гэдэг юм уу, эсвэл энэ нөхцөл байдлыг шийдэж авахгүй бол бид нар буцаад ухралт болно шүү гэж. Үндэсний цөөнх бол эх хэл дээрээ мэдээлэл авах ёстой.

Өөрөөр хэлбэл, төрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авах ёстой, нийгмийн амьдралтай холбоотой мэдээлэл авах ёстой, эдийн засаг, ахуйн харилцаанд орохтой холбоотой мэдээлэл авах ёстой. Энэ бол байгаа 3 хуулийн тэр зөрчлөөс болоод асуудал болчихсон. Радио одоо тусгай зөвшөөрлийг нь өгөхгүй байгаа юм. Энийг бид нар энд бас ярьж байх ёстой. Бид заримдаа шинэ зүйлийг яриад байгаа мөртөө урьд нь бидэнд байсан сайн туршлагыг ярихаа байчихлаа. Ярихаар зарим нь эмээдэг болчихлоо. Би хууль тогтоогчийн хувьд энийг бол ажлын хэсэгт бол саналаа танилцуулна гэж бодож байгаа юм. Бид та бүхнийг бас энийг бодвол бас судалж энэ дээр зөвлөмж гаргаач гэж хүсэж байна. Гарах ч ёстой юм байгаа юм. Би та бүхэнтэй бас тухайлан уулзалт хийе гэж бодож байна. Энэ бол зүгээр л хуулиар зохицуулаад л хийх ёстой зүйл юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн анхаарч өгөөч гэж байгаа юм.

Дараа нь бас өөр асуудлууд байгаа. Тэрийг бол та бүхэнтэй уулзахдаа ярилцъя гэж бодож байна. Ингээд бид энэ жил болгон тайлангаа холбогдох Байнгын хороод ороод сонсоод, та бүхнээсээ зөвлөмж, та бүхний саналыг сонсохын зэрэгцээ бид бас өөрсдөө яаж ажиллах вэ гэдэг талаар бас тодорхой ойлголттой болж байгаа нь тийм сайшаалтай гэж бодож байгаа шүү дээ. Манай парламентын давуу тал бол энэ. Бид хэлэлцэж чаддаг, хэлснийхээ дагуу зөв шийдвэр гаргахын тулд тал талын оролцоог хангаж чаддаг ийм л улс орон гэдгээ харуулж байгаа учраас энэ зүйл их чухал шүү. Байнгын хороо энэ дээр идэвхтэй ажиллаж байгаад бас талархалтай байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд санал хэлж дууслаа.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэж дууслаа.

Энэ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос Монгол Улсын Их Хурлаар, Үндэсний комиссоос түрүүн илтгэлдээ гаргасан шүү дээ 6, 7 санал байгаа тээ? Энэ 7 саналыг санал, дүгнэлтдээ тусгая.

Ингээд илтгэлийн хэлэлцэж дууслаа. Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороон дээр Уянгахишиг гишүүн танилцуулах уу? Уянгахишиг гишүүн танилцуулъя.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг өндөрлүүлж байна.

15.15 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР